



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 10 сарын 07 өдөр

дугаар 34

Улаанбаатар хот

Г Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах  
брокерыг гишүүнээр элсүүлэх тухай

7

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.20, Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ Нь:

1. "Голомт Капитал УЦК" ХК-ийг "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн гишүүнээр элсүүлсүгэй.
2. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журмын дагуу "Голомт Капитал УЦК" ХК-тай "Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн гэрээ" байгуулахыг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д даалгасугай.
3. Үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаанд чанд мөрдөж ажиллахыг "Голомт Капитал УЦК" ХК /С.Ган-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.
4. Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын бэх оффис (back office)-ын системийн хөгжүүлэлт болон арилжаа эрхлэгч байгууллагын системтэй шаардлагатай холболтыг бүрэн хийж 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс өмнө дуусгахыг "Голомт Капитал УЦК" ХК /С.Ган-Эрдэнэ/-д даалгасугай.
5. Хууль тогтоомж болон зах зээлд мөрдөгдөж буй журам, заавар, гишүүнчлэлийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1523010093



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 10 сарын 17 өдөр

дугаар 35


Улаанбаатар хот

Г Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах  
брокерыг гишүүнээр элсүүлэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.20, Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ Нь:

1. "Ти Ди Би Секьюритис УЦК" ХК-ийг "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн гишүүнээр элсүүлсүгэй.
2. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журмын дагуу "Ти Ди Би Секьюритис УЦК" ХК -тай "Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн гэрээ" байгуулахыг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д даалгасугай.
3. Үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандaa чанд мөрдөж ажиллахыг "Ти Ди Би Секьюритис УЦК" ХК /С.Батчимэг/-д үүрэг болгосугай.
4. Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын бэк оффис (back office)-ын системийн хөгжүүлэлт болон арилжаа эрхлэгч байгууллагын системтэй шаардлагатай холболтыг бүрэн хийж 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс өмнө дуусгахыг "Ти Ди Би Секьюритис УЦК" ХК /С.Батчимэг/-д даалгасугай.
5. Хууль тогтоомж болон зах зээлд мөрдөгдөж буй журам, заавар, гишүүнчлэлийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1523010092



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 10 сарын 17 өдөр

дугаар 36

Улаанбаатар хот

Г

Г

Хамтын биржээр арилжаалагддаг  
хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн  
бүртгэлийн журам батлах тухай


Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.3, 49 дүгээр зүйлийн 49.1.4, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалтууд, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.22 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ Нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн "Хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ыг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолоор баталсан "Хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ыг Санхүүгийн зохицуулах хороонд танилцуулж, батламжуулахыг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д үүрэг болгосугай.
3. Энэхүү "Хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ыг Санхүүгийн зохицуулах хорооноос батламжлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Н.Улаанхүү/-нд үүрэг болгосугай.



Д.ТОГТОХБАЯР

1523010099



## ХАМТЫН БИРЖЭЭР АРИЛЖААЛАГДДАГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх (цаашид “нэгж эрх” гэх)-ийг Монголын хөрөнгийн бирж (цаашид “Бирж” гэх)-ийн үнэт цаасны бүртгэлд бүртгэх, бүртгэлийн шалгуурыг тогтоох, нэгж эрхийг санал болгох, арилжааг түр зогсоох, сэргээх, бүртгэлээс хасах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шударга, ил тод, шуурхай явуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү журмыг Биржийн нэгж эрхийн бүртгэлд бүртгэгдсэн, бүртгүүлэхээр хүсэлт гаргасан хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сан /цаашид “Сан” гэх/, түүний үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани /цаашид “үүсгэн байгуулагч” гэх/, Төлөөлөн Удирдах Зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/-ийн гишүүн болон бусад эрх бүхий албан тушаалтан, мэргэжлийн оролцогч, кастодиан, аудитор, хуульч, хөрөнгийн үнэлгээчин болон холбогдох бусад этгээд дагаж мөрдөнө.
- 1.3 Журмын уг, өгүүлбэр нь хоёрдмол утга илэрхийлэх тохиолдолд, Бирж нь хүчин төгөлдөр хууль тогтоомжид нийцүүлэн журмыг тайлбарлах эрхтэй байна.

### Хоёр. Хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг биржийн бүртгэлд бүртгэх

- 2.1 Нэгж эрх бүртгүүлэх тухай өргөдөлд үүсгэн байгуулагчийн ТУЗ-ийн дарга, Гүйцэтгэх удирдлага гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан байна. Нэгж эрх бүртгүүлэх хүсэлтэд дараах бичиг баримтыг хавсаргана:
  - 2.1.1 Нэгж эрх бүртгүүлэх өргөдөл /Маят 1/;
  - 2.1.2 Нэгж эрх гаргагч Сангийн мэдэгдэл /Маят 2/;
  - 2.1.3 Нэгж эрхийг анхдагч зах зээлд санал болгож, санхүүгийн хэрэгслээр солилцох үйл ажиллагааг хэрэгжүүлэх мэргэжлийн оролцогчийн мэдэгдэл /Маят 3/;
  - 2.1.4 Нэгж эрх гаргах тухай үүсгэн байгуулагчийн шийдвэр;
  - 2.1.5 Хороонд бүртгүүлсэн нэгж эрхийн танилцуулга;
  - 2.1.6 Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
  - 2.1.7 Сангийн дүрмийн хуулбар;
  - 2.1.8 Сангийн эхлэлтийн санхүүгийн тайлан;
  - 2.1.9 Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг;
  - 2.1.10 Хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний гэрээний хуулбар;
  - 2.1.11 Мэргэжлийн оролцогч болон үүсгэн байгуулагчийн хооронд гэрээ байгуулахаар тохиролцсон амлалт бичиг;
  - 2.1.12 Кастодиантай байгуулсан гэрээний хуулбар;
  - 2.1.13 Зах зээл үүсгэгчтэй байгуулсан гэрээний хуулбар;
  - 2.1.14 Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хороо /цаашид Хороо гэх\*-ны журамд заасан журмуудын төсөлтэй хуулбар;
  - 2.1.15 Сангийн үүсгэн байгуулагч, кастодиан, аудитор, хуулийн зөвлөх, мэргэжлийн оролцогч зэрэг байгууллагуудын дэлгэрэнгүй мэдээлэл;

- 2.1.16 Сангийн болон үүсгэн байгуулагчийн гүйцэтгэх удирдлага болон мэргэжилтнүүд Хороо-ноос тогтоосон тохиромжтой этгээдийн шаардлагуудыг хангаж байгааг нотлох баримт;
- 2.1.17 Хөрөнгө итгэмжлэн удирдах менежментийн компанийн дүрэм, санхүүгийн тайллан;
- 2.1.18 Санг нэгээс дээш тооны хөрөнгө оруулалтын менежментийн компани хамтран үүсгэн байгуулж байгаа тохиолдолд тэдгээрийн хооронд байгуулсан гэрээний эх хувь эсхүл нотариатаар баталгаажуулсан хуулбар;
- 2.1.19 Энэ журмын 7 дугаар зүйлд заасан өргөдөл хүлээн авах, хянах үйлчилгээний хөлс төлсөн баримт.
- 2.1.20 Биржээс шаардлагатай гэж үзсэн бусад бичиг баримт.
- 2.2 Нэгж эрхийн танилцуулгад Хорооны "Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих тухай журам"-ын 4 дүгээр зүйлд зааснаас гадна дараах мэдээллийг тусгасан байна:
- 2.2.1 Сангийн үндсэн шинж чанар, давуу, сул тал, бусад нээлттэй сангаас ялгарах онцлог, сангийн нэгж эрхийг гаргахад оролцох талууд, сангийн нэгж эрхийг гаргах процессыг харуулсан зураглал зэрэг мэдээлэл;
- 2.2.2 Мэргэжлийн оролцогч болон зах зээл үүсгэгчийн гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагын тухай, тэдгээрийн нэр, холбоо барих хаяг, мэдээлэл;
- 2.2.3 Мэргэжлийн оролцогчтой байгуулсан гэрээний гол нэхцэл, түүний тайлбар;
- 2.2.4 Үнэт цаасны индексийн сангийн хувьд дараах мэдээлэл:
- 2.2.4.1 индексийн танилцуулга, түүний багцыг бүрдүүлэгч үнэт цаасны жагсаалт;
- 2.2.4.2 индексийн багцад багтдаг үнэт цаас өөрчлөгдөх нэхцэл;
- 2.2.4.3 эрсдэлийн хүчин зүйлс;
- 2.2.4.4 нэгж эрхийн танилцуулга бэлтгэснээс хойш нэг сарын доторх индексийн багцад багтаж буй үнэт цаас, тэдгээрийн индексэд эзлэх хувийн жин;
- 2.2.4.5 индексийн багцыг шинэчлэх давтамж;
- 2.2.4.6 хөрөнгө оруулагч индексийн талаар мэдээлэл олж авах арга хэлбэр.
- 2.2.5 Нэгж эрхийг үүсгэх, буцаан худалдан авахтай холбоотой дараах мэдээлэл:
- 2.2.5.1 Нэгж эрхийг хоёрдогч зах зээлд шинээр үүсгэх, буцаан худалдан авах нэхцэл, дэлгэрэнгүй тайлбар;
- 2.2.5.2 Нэгж эрхийг Бирж дээр арилжих журам;
- 2.2.5.3 Нэгж эрхийг үүсгэх, буцаан худалдан авах хуваарь;
- 2.2.6 Нэгж эрхийн цэвэр активын үнэлгээг тооцоолох аргачлал, мэдээлэх давтамж, түүнийг тооцоолон нийтэд мэдээлэх этгээдийн талаар;
- 2.2.7 Хөрөнгө оруулагчаас нэгж эрх өзөмшихтэй холбогдон гарах нийт зардлын бүтэц, хэмжээг харуулсан дэлгэрэнгүй мэдээлэл /Маягт 4/;
- 2.3 Танилцуулгын эхний хуудсанд дараах анхааруулгыг тодор бичсэн байна:  
"Хамтын Биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг Монголын Хөрөнгийн Бирж бүртгэсэн нь уг нэгж эрхийн эрсдэлийн талаар аливаа баталгаа гаргаагүй болохыг анхаарах нь зүйтэй. Үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани болон түүний удирдаж байсан бусад сангийн үйл ажиллагааны түүхэн гүйцэтгэл нь энэхүү нэгж эрхийг гаргаж буй сангийн ирээдүйн гүйцэтгэлийн баталгаа болохгүй. Энэхүү нэгж эрхийг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагч Таны хувьд ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ үйлдэл байдгийг онцгойлон анхаарч, нэгж эрхийн танилцуулга, нэгж эрх гаргах ажиллагааг сайтар

анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна."

- 2.4 Нэгж эрхийн танилцуулгад Сангийн удирдлага гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан байх бөгөөд "Биржид ирүүлж байгаа танилцуулга, бусад баримт бичиг нь Хороонд хүргүүлж байгаа танилцуулга, баримт бичигтэй адил, танилцуулгад ямар нэг зөрүүтэй мэдээлэл тусгагдаагүй болно" гэсэн баталгаа гаргасан байна.
- 2.5 Сан нь энэ журамд заасны дагуу өргөдөл, нэгж эрхийн танилцуулга болон хавсаргах бичиг баримтыг зохих шаардлагын дагуу бүрдүүлж, эх хувийг хэвлэмэл хэлбэрээр Биржид хүргүүлнэ.
- 2.6 Бирж нэгж эрх бүртгүүлэх өргөдлийг хянан шалгах, бүртгэх, бүртгэхээс татгалзах шийдвэр гаргахдаа Биржийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 8 дугаар зүйлийг баримтална.

**Гурав. Сангийн нэгж эрхийн бүртгэлийн шалгуур, шаардлага**

- 3.1 Сан нь Биржид бүртгүүлэхэд болон бүртгэлтэй байх хугацаанд энэ журамд заасан шалгуурыг хангаж ажиллана.
- 3.2 Биржийн бүртгэлд бүртгүүлэх Сан нь дараах шалгуурыг хангасан байна:
  - 3.2.1 Нэгж эрхийн танилцуулгыг боловсруулж, Хороонд бүртгүүлсэн байх;
  - 3.2.2 Сангийн эрх бүхий албан тушаалтан нь Хорооны тохиромжтой этгээдийн шаардлагыг хангасан байх;
  - 3.2.3 Сангийн активын багцыг бүрдүүлэх суурь хөрөнгө оруулалтын хэрэгсэл нь Хорооноос хүлээн зөвшөөрсөн, хөрвөх чадвар сайтай хэрэгслүүд байх;
  - 3.2.4 Сангийн активын багцыг бүрдүүлэх суурь хөрөнгө оруулалтын хэрэгсэл нь барьцаалагдах зэргээр гуравдагч этгээдийн эрхээр хязгаарлагдаагүй, битүүмжлэгдээгүй, өмчлөх эрхийг шилжүүлэхэд аливаа хязгаарлалтгүй, чөлөөтэй шилжих, арилжигдах боломжтой байх;
  - 3.2.5 Кастодиантай хөрөнгө хадгалах, үүсгэн байгуулагчтай итгэмжлэн удирдах, мэргэжлийн оролцогчтой нэгж эрхийг анхдагч зах зээлд санхүүгийн хэрэгслээр солилцох, хоёрдогч зах зээлд шинээр үүсгэх, буцаан худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх гэрээг байгуулсан байх;
  - 3.2.6 Сангийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хоёрдогч зах зээлд шинээр нэгж эрх үүсгэх, нэгж эрхээ буцаан худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх хоёроос доошгүй мэргэжлийн оролцогчтой гэрээ байгуулсан эсхүл гэрээ байгуулахаар тохиролцсон байх;
  - 3.2.7 Сангийн цэвэр активын үнэлгээг тооцоолох хүний нөөц болон программ хангамж, олон нийтэд тогтмол мэдээлэх цахим хуудастай байх;
  - 3.2.8 Нэгж эрх эзэмшигчдэд мэдээлэл өгөх, харилцах цахим хуудас, телефон утас тогтмол ажиллуулах.
- 3.3 Мэргэжлийн оролцогч нь дараах шалгуур, шаардлагыг хангасан байна. Үүнд:
  - 3.3.1 Хоёроос доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан, Биржийн гишүүн үнэт цаасны компани байх;
  - 3.3.2 Өөрийн хөрөнгийн хэмжээ 300 сая төгрөгөөс доошгүй байх;
  - 3.3.3 Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага, сонирхлын зөрчил зэргийг зохицуулах дүрэм журам, дотоод хяналтын найдвартай системтэй байх;
  - 3.3.4 Сүүлийн хоёр жилийн хугацаанд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хорооны болон Биржийн дүрэм, журмуудыг зөрчсөн зөрчил гаргаагүй байх;
  - 3.3.5 Сангийн нэгж эрх шинээр үүсгэх, буцаан худалдан авахтай холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэх чадвартай хүний нөөц, программ хангамжтай байх;

- 3.3.6 Сангийн активын багцыг нэгж эрхийн хөрвөх чадварыг хангах санхүүгийн хэрэгслээр бүрдүүлэх;
  - 3.3.7 Хорооны холбогдох журамд заасан бусад.
- 3.4 Үнэт цаасны индексийн сангийн хувьд индекс нь дараах шалгуур, шаардлагыг хангасан байна. Үүнд:
  - 3.4.1 Дотоодын зах зээлд эсвэл Хорооноос зөвшөөрсөн гадаадын арилжаа эрхлэх байгууллагаас тооцон гаргадаг индекс байх;
  - 3.4.2 Гуравдагч этгээдээр индексийн тооцооллыг гүйцэтгүүлэх тохиолдолд тухайн этгээд нь сантай нэгдмэл сонирхолтой этгээд биш байх;
- 3.5 Сан нь нэгж эрхийн хөрвөх чадварыг хангах зорилгоор зах зээл үүсгэгчийг гэрээний үндсэн дээр ажиллуулж болно.

#### **Дөрөв. Нэгж эрхийг шинээр үүсгэх, буцаан худалдан авах**

- 4.1 Биржийн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлсэн сан нь нэгж эрхийг шинээр үүсгэх, буцаан худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх тохиолдолд нэгж эрхийн бүртгэлд өөрчлөлт оруулах бөгөөд уг өөрчлөлтийг Биржийн бүртгэлд бүртгүүлнэ.
- 4.2 Сангийн нэгж эрхийг шинээр үүсгэх болон буцаан худалдан авах доод хэмжээг нэгж эрхийн танилцуулгад тусгасан байна.
- 4.3 Сангийн эргэлтэд гаргасан нийт нэгж эрхийг бүхэлд нь эргүүлэн худалдан авах саналыг сайн дурын үндсэн дээр бүртгэлээс хасуулах хүсэлт гаргасан гэж үзнэ.
- 4.4 Сангийн нэгж эрхийг сангийн багцыг бүрдүүлж байгаа хөрөнгө оруулалтын хэрэгслээр солих тохиолдолд үүсгэн байгуулагч болон кастодиан нь хөрөнгө оруулалтын хэрэгслийг нэгж эрх эзэмшигчид ажлын 15 өдрийн дотор шилжүүлнэ.
- 4.5 Буцаан худалдан авсан аливаа нэгж эрхийг дүрмийн сангаас хасах эсэхийг сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 4.6 Буцаан худалдан авсан боловч дүрмийн сангаас хасаагүй аливаа нэгж эрхийг гаргаагүй нэгж эрх гэж үзэх бөгөөд сангийн үйл ажиллагаа явуулах хугацаанд дахин гаргаж болно.
- 4.7 Сангийн нэгж эрхийг шинээр үүсгэх, эсхүл буцаан худалдан авч эргэлтээс гаргах тохиолдолд кастодиан нь нэгж эрх шинээр үүсгэсэн, эсхүл буцаан худалдан авсан тухай мэдэгдлийг /Маягт 6/ цахим хэлбэрээр Биржид ирүүлнэ.
- 4.8 Бирж нь нэгж эрхийн Бүртгэлд өөрчлөлт оруулах тухай мэдэгдэл /Маягт 5/ болон шийдвэрийн хуулбарыг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад хүргүүлнэ.

#### **Тав. Сангийн бүртгэлтэй байх хугацаанд биелүүлэх үүрэг**

- 5.1 Сан нь Монгол Улсын үнэт цаасны зах зээл дээр мөрдөгдөж буй хууль, тогтоомж, журам, зааварт туссан хөрөнгө оруулагчдын болон эрх бүхий байгууллагын өмнө хүлээсэн үргээ бүрэн биелүүлж ажиллана.
- 5.2 Сан нь бүртгэлтэй байх хугацаандаа энэхүү журамд заасан шалгуурыг хангаж ажиллахаас гадна дараах үүргийг биелүүлж ажиллана:
  - 5.2.1 Хорооны холбогдох журам, зааварт заасан шалгуур, шаардлагыг хангаж ажиллах;
  - 5.2.2 Нэгж эрх эзэмшигчдийн хурлын шийдвэрийг хууль журамд заасан хугацаанд Биржид ирүүлж, олон нийтэд мэдээлэх. Үүнээс хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг өөрчлөх, цуцлах, түр зогсоох, сангийн нэгж эрхийг бүртгэлээс хасах, хөрөнгө оруулалтын менежментийн компанийг нэгтгэх, хуваах, татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, дампуурлын хэрэг үүсгэх, түүний үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хугацаа дуусах эсхүл цуцлагдах, шинэ хөрөнгө

- оруулалтын менежментийн компанид хөрөнгө итгэмжлэн удирдах эрхийг шилжүүлэх, аудиторыг солих, индекс тооцоологчийн гэрээг цуцлах, индексийн тооцооллыг зогсоох, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад мэдэгдэхүйц нөлөө үзүүлж болох сангийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар гарсан шийдвэр буюу мэдээллийг тухай бүр өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж, Биржид ирүүлнэ;
- 5.2.3 Энэ журмын 3.4-т заасан шаардлага болон хөрвөх чадварын шаардлагыг хангаж ажиллах бөгөөд сангийн нэгж эрхийн хөрвөх чадварыг дараах үзүүлэлтээр хэмжинэ;
- 5.2.3.1 сангийн нэгж эрхийн хөрвөх чадварын үзүүлэлт
- 5.2.3.2 суурь үнэт цаасны хөрвөх чадварын үзүүлэлт
- 5.2.3.3 сангийн нэгж эрхийн болон суурь үнэт цаасны багцын харьцуулсан үзүүлэлт
- 5.2.4 Нэгж эрх эзэмшигчидтэй харилцах алба, нэгж, байнгын ажлын байртай байх ба хөрөнгө оруулагчдад хууль тогтоомжийн дагуу мэдээ, мэдээлэл өгөх утас, цахим хуудсыг тогтмол ажилууллах;
- 5.2.5 Сангийн активын багцыг бурдуулж буй хөрөнгө оруулалтын хэрэгсэл (үнэт цаасны хувьд нэр, код)-ийн нэр төрөл, тоо ширхэг, цэвэр активын үнэлгээ, нэгж эрхийн үнэ, үүсгэсэн нийт нэгж эрхийн тоо, шинээр үүсгэсэн болон буцаан худалдаж авсан нэгж эрхийн тоо ширхэг, үнэт цаасны индексийн сан бол тухайн индексийн өсөлт, бууралт, индекс болон сангийн өгөөжийн зөрүү (tracking error, difference)-ний мэдээллийг өдөр бүр өөрийн цахим хуудсаар дамжуулан 2 хүртэл минутын хоцрогдолтойгоор эсвэл үнэт цаасны танилцуулгад тусгасан цагт олон нийтэд мэдээлэх, Биржид цахим холболтоор дамжуулах;
- 5.2.6 Сангийн цэвэр активын өөрчлөлт, хэрэгжсэн болон хэрэгжээгүй ашиг, алдагдлын тооцоолол, удирдлагын зардал, сангийн нэгж эрх эзэмшигчид төлсөн ногдол ашиг, сангийн активыг бурдуулж буй хөрөнгө оруулалтын хэрэгслийн нэр, эзлэх хувь зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан сангийн үйл ажиллагааны тайланг Хөрөнгө Оруулалтын Гүйцэтгэлийг Үнэлэх Олон Улсын Стандарт (GIPS)-ын дагуу хагас жил, жилийн эцсийн байдлаар гаргаж, хагас жилийн тайланг санхүүгийн тайлангийн хамт 7 дугаар сарын 20-ны дотор, жилийн тайланг санхүүгийн тайлангийн хамт жил бүрийн 4 дүгээр сарын 1-ний дотор Биржид ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэх;
- 5.2.7 Биржийн жилийн үйлчилгээний хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлж байх;
- 5.2.8 Сангийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, дүрэм, журам, эрх бүхий албан тушаалтан, холбоо барих хаяг, байршил, утас, хөрөнгө оруулалтын менежментийн компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц зэрэгт өөрчлөлт орсон тохиолдолд өөрчлөлтийг ажлын 3 хоногийн дотор Биржид мэдэгдэх;
- 5.2.9 Эрх бүхий байгууллагаас санд авсан арга хэмжээний тухай ажлын 2 хоногийн дотор Биржид бичгээр мэдэгдэх;
- 5.2.10 Ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд ажлын 3 хоногийн дотор ногдол ашгийн хэмжээ, төлөх өдөр, бүртгэх өдрийн талаар мэдээлэл ирүүлэх;
- 5.2.11 Кастодиан, мэргэжлийн оролцогч, индекс тооцоологчтой байгуулсан гэрээг цуцлах, өөрчлөх тохиолдолд Биржид энэ тухай 30 хоногийн өмнө мэдэгдэх;
- 5.2.12 Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, ҮЦЗЗТХ-д заасан бусад мэдээллийг тухай бүр ирүүлэх.

- 5.3 Сангийн төлөөлөн удирдах зөвлөл нь үүсгэн байгуулагч энэ журамд заасан мэдээ, мэдээллийг заасан хугацаанд Биржид ирүүлэн, олон нийтэд мэдээлж байгаа эсэхэд хяналт тавина.

**Зургаа. Нэгж эрхийн арилжааг түр зогсоох, бүртгэлээс хасах**

- 6.1 Нэгж эрхийн арилжааг зогсоохдоо Хорооны Улсын байцаагчийн шийдвэрийг үндэслэх ба дараах тохиолдлуудад арилжааг түр зогсоох тухай Хороонд санал хүргүүлнэ. Үүнд:
- 6.1.1 Сан нь тогтмол биелүүлэх үүргээ биелүүлэгүйгээс хөрөнгө оруулагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үссэн;
- 6.1.2 Биржээс хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах үүднээс тухайн сангийн үйл ажиллагаа, нэгж эрхийн арилжаанд хяналт шалгалт хийх шаардлагатай гэж үзсэн;
- 6.1.3 Мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа зогссоноос хойш 1 сарын хугацаа өнгөрсөн;
- 6.1.4 Цэвэр активын хэмжээ нь дараалсан 10 хоногийн туршид тухайн сан үйл ажиллагаагаа эхлүүлсэн өдрийн хэмжээнээс 40 хувь ба түүнээс дээш хэмжээгээр буурсан;
- 6.1.5 Хөрөнгө оруулалтын менежментийн компани татан буугдах эсвэл түүний хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл түдгэлzsэн, цуцлагдсан эсвэл кастодиан татан буугдах, дампуурах нөхцөл байдал бий болсны улмаас холбогдох гэрээний эрх, үүргийг эрх бүхий өөр этгээдэд шилжүүлэх шаардлага үссэн;
- 6.1.6 Эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн;
- 6.1.7 Цэвэр активын үнэлгээг зохих журмын дагуу тооцож, олон нийтэд мэдээлэх нөхцөлийг хангагүй;
- 6.1.8 Өөр арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй сангийн нэгж эрхийн арилжааг тухайн бирж дээр зогсоосон тохиолдолд;
- 6.1.9 Хөрөнгө оруулагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөх бусад нөхцөл байдал.
- 6.2 Тухайн сангийн нэгж эрхийг Сангийн хүсэлтээр Биржийн нэгж эрхийн бүртгэлээс хасахаас гадна дараах тохиолдлуудад нэгж эрхийн бүртгэлээс хасна. Үүнд:
- 6.2.1 Тогтмол биелүүлэх үүргээ удаа дараа биелүүлэгүй;
- 6.2.2 Энэхүү журмын 6 дугаар зүйлийн 6.1-д заасан үндэслэлээр нэгж эрхийн арилжаа зогссоноос хойш зургаан сарын хугацаанд зөрчил эсхүл үссэн нөхцөл байдал арилаагүй;
- 6.2.3 Сангийн нэгж эрх эзэмшигчдийн шийдвэрээр өөр хөрөнгө оруулалтын сантай нэгдэх замаар өөрчлөн байгууллагдахаар болсон;
- 6.2.4 Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа явуулах хугацаа дуусгавар болсон;
- 6.2.5 Өөр арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй сангийн нэгж эрхийг тухайн биржийн бүртгэлээс хассан тохиолдолд;
- 6.2.6 Нэгж эрх эзэмшигчдийн хурлаар шийдвэр гаргасан тохиолдолд;
- 6.2.7 Хууль тогтоомжинд заасан бусад үндэслэл.
- 6.3 Нэгж эрхийн арилжааг дараах тохиолдолд сэргээх тухай Хороонд мэдэгдэл хүргүүлнэ. Үүнд:
- 6.3.1 Сан нь гаргасан зөрчлөө арилгасан тухайгаа мэдэгдсэн, эсхүл Биржээс уг зөрчлийг арилсан гэж тогтоосон;
- 6.3.2 Зохицуулах эрх бүхий байгууллага, шүүх хяналтын байгууллагаас Санд авсан арга хэмжээг үндэслэлгүй гэж үзсэн;
- 6.3.3 Хууль тогтоомж, дүрэм, журамд заасан бусад үндэслэл.

## **Долоо. Үйлчилгээний хөлс**

- 7.1 Санд Биржээс үзүүлэх үйлчилгээний хөлс нь дараах төрөлтэй байна:
- 7.1.1 Бүртгүүлэх өргөдөл хүлээн авч хянах үйлчилгээний хөлс – Сан нь Биржид нэгж эрхийг анх удаа бүртгүүлэх хүсэлт гаргахдаа өргөдөл хүлээн авч хянах үйлчилгээний хөлсийг буцаан олгогдохгүй нөхцөлтэйгээр энэ журмын хавсралт 1-д заасны дагуу төлөх бөгөөд шинээр үүсгэх нэгж эрхийг бүртгэхэд энэ заалт хамаарахгүй.
- 7.1.2 Нэгж эрхийг бүртгэх үйлчилгээний хөлс – Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлсийг сангийн нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн хавсралт 1-д заасны дагуу хувиар тооцож нэгж эрхийн хоёрдогч зах зээл эхлэхээс 3 өдрийн дотор Биржийн дансанд шилжүүлнэ.  
*/Энэхүү заалтыг 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/*
- 7.1.3 Жилийн үйлчилгээний хөлс – Жилийн үйлчилгээний хөлсийг сангийн цэвэр активын жилийн дундаж дүнгээс хавсралт 1-д заасан хэмжээгээр тооцож, тухайн оны нэгдүгээр улиралд багтаан Биржийн дансанд шилжүүлнэ  
*/Энэхүү заалтыг 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/*
- 7.2 Шинээр үүсгэсэн нэгж эрхийг бүртгэх үйлчилгээний хөлсийг энэ журмын 7.1.2-д заасны дагуу тооцон тухай бүр төлнэ.

## **Найм. Хариуцлага**

- 8.1 Сан, түүний эрх бүхий албан тушаалтан болон хамтран ажиллаж буй мэргэжлийн байгууллага нь энэхүү журам болон бусад холбогдох дүрэм, журмыг зөрчсөн эсхүл хэрэгжүүлээгүй тохиолдолд энэ журам болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 8.2 Сан нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг хэрхэн мөрдөж байгаад энэхүү журмын 8.1-д заасны дагуу Биржээс хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар Сан, түүний холбогдох этгээдэд шаардлага хүргүүлж, журам болон гэрээний дагуу хариуцлага ногдуулж болно.
- 8.3 Сан, түүний эрх бүхий албан тушаалтан болон холбогдох этгээдэд дараах хэлбэрийн хариуцлагыг хамтад нь эсхүл тус тусад нь тооцно.
1. Сануулах;
  2. Гэрээний хариуцлага ногдуулах;
  3. Нэгж эрхийн арилжааг зогсоох тухай мэдэгдэл Хороонд хүргүүлэх;
  4. Нэгж эрхийг бүртгэлээс хасах.
- 8.4 Ногдуулах хариуцлагын хэлбэрийг сонгохдоо Бирж нь Сан, түүний эрх бүхий албан тушаалтан болон холбогдох этгээдийн гаргасан зөрчлийн шинж чанар, гэм буруутай байдлыг харгалзаж үзнэ.
- 8.5 Нэгж эрхийн танилцуулга, холбогдох баримт бичгийг бэлтгэхэд оролцсон этгээд өөрийн гүйцэтгэсэн ажилтай холбоотойгоор бусдад учруулсан хохирлыг тус бүртээ хариуцна.

## **ЕС. Бусад**

- 9.1 Сан нь Биржээс Сантай холбоотой буюу Биржид бүртгэлтэй нэгж эрхтэй холбоотойгоор гаргасан аливаа шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг гардан авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор Хороонд гомдол гаргаж болно.
- 9.2 Биржийн хяналт шалгалт хариуцсан алба Сангийн үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, журам, заавар, гэрээний үүргийн биелэлтэд хяналт шалгалтын холбогдох

журамд заасны дагуу зайны хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд газар дээрх шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулна.

-о0о-

## Хавсралт 1

### ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС

#### 1. Бүртгүүлэх өргөдөл хүлээн авч хянах үйлчилгээний хөлс

Хүснэгт 1 /төгрөгөөр/

Бүртгүүлэх өргөдөл хүлээн авч хянах үйлчилгээний хөлс /шинээр үүсгэх нэгж эрхийг бүртгэхэд хамаарахгүй/	2,000,000
---	-----------

#### 2. Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс

Хүснэгт 2 /төгрөгөөр/

	Дотоодын зах зээлд арилжаагддаг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах сангийн хувьд	Хорооноос зөвшөөрсөн гадаадын арилжаа эрхлэх байгууллага дээр арилжаалагддаг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах сангийн хувьд
Нийт бүртгүүлсэн үнийн дунгээс тооцно	Нийт бүртгүүлсэн үнийн дунгийн 0.03 хувь,	Нийт бүртгүүлсэн үнийн дунгийн 0.05 хувь,
Дээд хэмжээ Доод хэмжээ	2,000,000 20,000,000	

/Энэхүү заалтыг 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/

#### 3. Жилийн үйлчилгээний хөлс

Хүснэгт 3 /төгрөгөөр/

Сангийн цэвэр активын жилийн дундаж дунгийн 0.025 хувь	Хамгийн багадаа 2,500,000 төгрөг, хамгийн ихдээ 25,000,000 төгрөг байна.
--	--

/Энэхүү заалтыг 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/

## БҮРТГЭЛИЙН ӨРГӨДЛИЙН МАЯГТ

Хэнд: "Монголын хөрөнгийн бирж" ХК,  
Бүртгэлийн алба

Огноо: .....

Эрхэм Танаа,

Бид ..... [Хамтын Биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сан, түүнийг төлөөлж] энэхүү маягтын 2-т тусгасан нэгж эрхийг Санхүүгийн Зохицуулах Хорооны холбогдох журам болон "Монголын Хөрөнгийн Бирж" ХК /цаашид "Бирж" гэх/-ийн "Биржээр арилаалагддаг сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ын дагуу бүртгүүлж, арилжаалах зөвшөөрөл авахаар энэхүү өргөдлийг гаргаж байна.

### I. Сангийн мэдээлэл:

1	Сангийн оноосон нэр:	
2	Хөрөнгө оруулалтын хэрэгслүүд:	
3	Хөрөнгө оруулалтын удирдлагын хэлбэр /идэвхтэй, идэвхгүй/:	
4	Үйл ажиллагаа явуулах хугацаа:	
5	Бүртгэлтэй улс, улсын бүртгэлийн дугаар:	
6	Регистерийн дугаар:	
7	Үүсгэн байгуулагдсан огноо:	
8	Үйлчилгээний зардлын хувь хэмжээ:	
9	Оршин байх албан ёсны хаяг: /Монгол Улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ/	
10	Хөрөнгө оруулагч, нэгж эрх эзэмшигчдэд мэдээлэл өгөх цахим хуудасны хаяг:	
11	Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:	
12	Өргөдөлтэй холбоотой асуудлыг хариуцах этгээдийн нэр, албан тушаал, хаяг, холбоо барих утас:	
13	Нэгж эрхийн 5 болон түүнээс дээш хувийг дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг нэгж эрх эзэмшигчийн талаарх мэдээлэл: /5 болон түүнээс дээш хувийг аж ахуйн нэгж эзэмшдэг бол түүний хяналтын багц эзэмшигч бенефициар өмчлөгчийг мөн бичнэ/	

14	Нэгж эрхийн код /үсгэн ба тоон/ Шинээр нэгж эрх бүртгүүлэх компани нь үнэт цаасанд олгох үсгэн кодны саналаа бичнэ:	
15	Бүртгүүлэх нэгж эрхийн тоо ширхэг, үнэ, үнийн дун:	
16	Нэгж эрх гаргах замаар татан төвлөрүүлэхээр тооцсон хөрөнгийн хэмжээ:	
17	Нэгж эрхийг арилжихаар төлөвлөсөн хугацаа:	

## II. Мэргэжлийн оролцогчийн мэдээлэл

1	Мэргэжлийн оролцогчийн оноосон нэр:	
2	Бүртгэлтэй улс, улсын бүртгэлийн дугаар:	
3	Регистерийн дугаар:	
4	Эрх бүхий байгууллагаас олгосон энэхүү үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар, огноо: /Нотлох баримтыг хавсаргана/	
5	Оршин байх албан ёсны хаяг;	
6	Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:	

Өргөдөл гаргасан:

1. Овог, нэр: .....

Албан тушаал:

“.....ҮЦК” ....-ийн  
ТУЗ-ийн дарга .....

2. Овог, нэр: .....

Албан тушаал:

“.....ҮЦК” -ийн  
ГЗ .....

Гарын үсэг:

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

(Тамга/тэмдэг)

ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ /зөвхөн Биржийн албан хэрэгцээнд/

Өргөдөл хүлээн авсан ажилтны овог, нэр:	Өргөдөл хүлээн авсан огноо, цаг, минут:	Өргөдөл, түүнд хавсаргасан баримтын тоо /нүүрээр/:

## САНГИЙН МЭДЭГДЭЛ

Огноо .....

### I. Сангийн мэдэгдэл:

1. Хамтын Биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сан.....[сан, түүнийг төлөөлж] бид өөрсдийн мэдлэг чадвараа бүрэн ашиглан дараах ажиллагааг хийж гүйцэтгэсэн гэдгээ мэдэгдэж байна:
  - 1.1 “Монголын хөрөнгийн бирж” ХК /цаашид “Бирж” гэх/-ийн “Хамтын Биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам” болон бусад хууль тогтоомжийн хүрээнд нэгж эрхийг гаргаж бүртгүүлэх, санал болгох, танилцуулхтай холбоотой шаардагдах бүхий л баримт бичгийг үнэн зөвөөр бүрдүүлсэн.
  - 1.2 Нэгж эрх бүртгүүлэхтэй холбоотой Биржийн “Хамтын Биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-д тусгагдсан нөхцөл шалгуурыг бүрэн хангасан.
  - 1.3 “Хамтын Биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-д заасан болон хууль, тогтоомжоор шаардах бусад мэдээллийг өргөдлийн хамт хүргүүлж байгаа баримт бичигт тусгасан. Хэрэв сүүлчийн хувилбар хүргэгдээгүй бөгөөд мэдээлэл дутуу бол дутуу мэдээллийг тусгаж, залруулан хүргүүлнэ.
  - 1.4 Нэгж эрх бүртгүүлэх, бүртгэлд өөрчлөлт оруулах зөвшөөрөл авахтай холбоотойгоор өргөдөл тусгасан мэдээлэлтэй зөрчилдөх ямар нэгэн баримт материал байхгүй болно. Хэрэв зөрчилдөх материал байх тохиолдолд Биржид нэн даруй мэдээлнэ.
  - 1.5 Худал, ташаа мэдээллийн улмаас үүсэх хариуцлагыг бид бүрэн хариуцна.
2. Түүнчлэн сангийн нэгж эрх нь Биржид бүртгэлтэй байх хугацаанд дараах үйл ажиллагааг тогтмол авч хэрэгжүүлэхийг мэдэгдэж байна:
  - 2.1 Манай нэгж эрх Биржид бүртгэгдсэн нөхцөлд Биржийн “Хамтын Биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам” болон бусад холбогдох журам, заавраар тогтоосон шалгуурыг хангаж ажиллах ба цаашид зохих дүрэм, журмыг баримталж ажиллана.
  - 2.2 Өргөдлийг хүлээн авч, нэгж эрхийг бүртгэх тухай шийдвэр гарсан тохиолдолд зохих хууль, журмын дагуу арилжааг эхлүүлэх хүсэлтээ Санхүүгийн Зохицуулах Хороо /цаашид “Хороо” гэх/ болон Биржид хүргүүлнэ.
  - 2.3 Бид “Хамтын Биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам” болон бусад холбогдох хууль, дүрэм, журамтай танилцсан бөгөөд нэгж эрх бүртгэлтэй хэвээр байх эсэх нь одоо болон ирээдүйд хүчин төгөлдөр мөрдөгдөх хууль дүрэм журмыг хэрхэн дагаж мөрдөхөөс хамааралтай болохыг хүлээн зөвшөөрч байна.

### II. Сангийн гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл:

1. Би .....[сангийн гүйцэтгэх удирдлага] өөрийн эрх мэдлийн хүрээнд Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн тухай хууль, тогтоомж болон Хороо, Биржийн холбогдох журам, зааврыг бүрэн дагаж, биелүүлэн ажиллана.
2. Дараах зүйлсийг Биржийн журамд заасан тогтоосон хугацаанд цаг алдалгүй хүргүүлнэ:
  - 2.1 Биржийн зүгээс хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор болон зах зээлийн үйл ажиллагааг хэвийн хангах зорилгоор шаардсан мэдээлэл баримтыг

- хүргүүлэх,
- 2.2 Биржийн зүгээс "Хамтын Биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ын хэрэгжилтийг хангах зорилгоор шаардсан тайлбар, баримт бичиг, мэдээллийг хүргүүлж, хамтран ажиллах,
- 2.3 Мөн өөрт шууд холбогдох асуудалд хариу тайлбар гаргаж өгөх,
3. Энэ журамд тодорхойлсон эрх бүхий албан тушаалтны шалгуур, нөхцлийг хангаж байгааг мэдэгдэж байна.
4. Би .... жилийн хугацаанд сангийн гүйцэтгэх удирдлагаар ажиллаж байгаа бөгөөд миний албан тушаал, холбогдох хаяг өөрчлөгдсөн тохиолдолд Биржид нэн даруй мэдэгдэнэ.
5. Нэгж эрх бүртгүүлэхээр хүргүүлж буй өргөдөл, түүний хавсралт материалд /нэгж эрхийн танилцуулга хамаарна/ орсон өөрийн тухай мэдээлэл нь бүгд үнэн зөв гэдгийг баталгаажуулж байна.
6. Энэхүү мэдэгдлийн 3, 4-т /дээрх заалтууд/ тусгасан мэдээллийг хугацаанд нь мэдэгдээгүй, буруу ташаа мэдээлэл хүргүүлсэн нь нотлогдвол түүнээс үүсэх хариуцлагыг хүлээнэ.

### **III. Биржээс үзүүлэх үйлчилгээний хөлстэй холбоотой мэдэгдэл:**

1. Бүртгүүлэх өргөдлийг хүлээн авч, хянах үйлчилгээний хэлс ..... төгрөгийг ... оны ... дугаар сарын ...-ны өдөр ..... банкны ..... дансанд төлсөн нь үнэн болно. /Төлбөр төлсөн баримтын хуулбарыг хавсаргах/
2. Олон нийтэд санал болгон худалдах нэгж эрхийн үнэ тодорхой болсон тохиолдолд журамд заасан хугацаанд тогтоосон хувь хэмжээгээр нэгж эрхийг бүртгэх үйлчилгээний хэлсийг Биржид төлөхөө мэдэгдэж байна.
3. Хэрэв Бирж нь өргөдөл тусгасан нэгж эрхийг бүртгээгүй, бүртгэхээс татгалзсан тохиолдолд "өргөдлийг хүлээн авч, хянах үйлчилгээний хэлс" нь буцаан олгогдохгүй болохыг хүлээн зөвшөөрч байна.
4. Хувьцаа нь бүртгэлтэй байх хугацаанд журмаар тогтоосон хувь хэмжээгээр, заасан хугацаанд нь жилийн үйлчилгээний хэлсийг төлөхөө мэдэгдэж байна.

**Баталгаажуулсан:**

**Баталгаажуулсан:**

Овог, нэр:

.....

Овог, нэр: .....

Албан тушаал:

Албан тушаал:

" ..... " -ийн

" ..... " -ийн

Гарын үсэг:

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

(Тамга/тэмдэг)

## МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН МЭДЭГДЭЛ

Огноо: .....

Бид ..... [үнэт цаасны компани, түүнийг төлөөлж]  
..... байршилтай, "Монголын хөрөнгийн бирж" ХК /цаашид  
"Бирж" гэх/-ийн "Хамтын Биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн  
бүртгэлийн журам" болон холбогдох бусад журамд заасны дагуу  
..... компанийн нэгж эрхийг олон нийтэд тогтмол санал болгоход  
мэргэжлийн оролцогчийн үүрэг гүйцэтгэх бөгөөд журамд заасны дагуу дараах мэдэгдлийг  
гаргаж байна:

1. Мэргэжлийн оролцогч нь Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж, дүрэм журмын бүхий л нөхцлийг мөрдөж ажилласан ба хүргүүлсэн материалд шаардлагатай мэдээллүүдийг бүрэн агуулсан, материал орхигдуулаагүй болно.
2. Нэгж эрхийн танилцуулга болон нэгж эрх бүртгүүлэх өргөдөлтэй хамт хүргүүлж буй Мэргэжлийн оролцогчийн мэдээллийг үнэн зөв, бодитой, бүрэн хийгдсэн гэж үзэж байна.
3. Бид нэгж эрхийн зах зээлийг бий болгон тогмол арилжаа хийх зэрэг ажиллагаанд шаардагдах мэргэшсэн, туршлагатай, холбогдох саналаа илэрхийлэх хангалттай нөөц бололцоотой гэж үзэж байна.
4. Сангийн удирдлагууд нь сангийн үйл ажиллагааг дангаар болон биеэ даан ажиллах туршлага, мэдлэг, чадвартай бөгөөд нэгж эрхээ Биржид бүртгүүлснээр хүлээх үүрэг хариуцлагаа ухамсарласан.
5. Сан нь нэгж эрхээ бүртгүүлэхээс өмнөх болон бүртгүүлсний дараах дагаж мөрдөх дүрэм журам, удирдлагын үүрэг хариуцлагатай холбоотой дотоод дүрэм журмыг бий болгосон гэж үзэж байна.

**Баталгаажуулсан:**

Овог, нэр: .....

**Баталгаажуулсан:**

Овог, нэр: .....

**Албан тушаал:**

"....." -ийн

**Албан тушаал:**

"....." -ийн

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

**ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭ, БҮТЭЦ**

A	Сангаас гарах нийт зардал /хөрөнгийн тухайн үеийн үнэ цэнээс жил бүр төлөх хувь хэмжээ/	%
1	Нийт үйлчилгээний зардлын хувь хэмжээ, жилээр	
1.1	- Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээнд	
1.2	- Хөрөнгө хадгалах үйлчилгээнд	
1.3	- Багц бүрдүүлэлтэнд /арилжааны шимтгэл, хураамж/	
1.4	- Бусад /зар сурталчилгаа, аудит гэх мэт/	
Б	Нэгж эрх эзэмшигчээс гарах зардал /хөрөнгө оруулалтын дүнгээс/	
2	Нэгж эрх худалдан авах, худалдахтай холбоотой зардал	

**ҮНЭТ ЦААСНЫ ХАДГАЛАМЖИЙН  
БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛЭХ  
МЭДЭГДЭЛ**

Хэнд: .....

№ .....

Огноо: .....

ҮЗҮҮЛЭЛТ	ШИНЭЭР ҮҮСГЭСЭН	ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ	БУЦААН ХУДАЛДАН АВЧ ЭРГЭЛТЭЭС ГАРГАСАН
Мэдэгдлийн агуулга:			
Үндэслэл:			
Санхүүгийн хэрэгсэл:			
Нэгж эрхийн нэр:			
Нэгж эрхийн код: /үсгэн, тоон/			
Суурь хөрөнгө оруулалтын хэрэгсэл:			
Үнэт цаасны хэлбэр: /биет, биет бус/			
Нийт нэгж эрхий тоо: /ширхэг/			
Нэгж эрхийн үнэ: /төгрөг/			
Нэгж эрхийн нийт үнийн дүн: /төгрөг/			
Бусад:			

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/...../

### БИРЖИД ХҮРГҮҮЛЭХ МЭДЭГДЭЛ

Хэнд: .....

№ .....

Огноо: .....

ҮЗҮҮЛЭЛТ	ШИНЭЭР ҮҮСГЭСЭН	ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ	БУЦААН ХУДАЛДАН АВЧ ЭРГЭЛТЭЭС ГАРГАСАН
<b>Мэдэгдлийн агуулга:</b>			
<b>Үндэслэл:</b>			
<b>Санхүүгийн хэрэгсэл:</b>			
<b>Нэгж эрхийн нэр:</b>			
<b>Нэгж эрхийн код:</b> /үсгэн, тоон/			
<b>Суурь хөрөнгө оруулалтын хэрэгсэл:</b>			
<b>Үнэт цаасны хэлбэр:</b> /биет, биет бус/			
<b>Нийт нэгж эрхий тоо:</b> /ширхэг/			
<b>Нэгж эрхийн үнэ:</b> /төгрөг/			
<b>Нэгж эрхийн нийт үнийн дүн:</b> /төгрөг/			
<b>Бусад:</b>			

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/...../

(Тамга/тэмдэг)

# ХАМТЫН БИРЖЭЭР АРИЛЖААЛАГДДАГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН ГЭРЭЭ

20... оны ... дугаар  
сарын -ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас "Монголын Хөрөнгийн Бирж" ХК /цаашид Бирж гэх/, түүнийг төлөөлж....., нэгөө талаас "....." Хамтын Биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын Сан /цаашид Сан, хамтад нь Талууд гэх/-ийг төлөөлж ..... нар дараах нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.

## Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү гэрээгээр Бирж нь Сан, түүний гаргасан нэгж эрхийг бүртгэх, нэгж эрхийн арилжааг зохион байгуулах ажиллагааг зохих дүрэм, журмын дагуу хийж гүйцэтгэх, сан нь холбогдох журмын дагуу Биржид бүртгэлтэй байх хугацаандаа зохих үргийг хүлээх, үйлчилгээний төлбөр төлөхтэй холбогдон үүсэх харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлно.
- 1.2 Бирж нь сангийн тогтмол гаргах.....-ийн үнэ ханшинд сууринсан нэгж эрхийг нэгж эрхийн бүртгэлд бүртгэнэ. Нэгж эрхийн сууринж буй актив, багц, индексийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан нэгж эрхийн танилцуулгыг хавсаргав.
- 1.3 Талуудын хооронд үүсэх энэхүү гэрээгээр зохицуулаагүй харилцааг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомж, Санхүүгийн Зохицуулах Хороо /цаашид Хороо гэх/, Биржээс баталсан журам, заавраар зохицуулна.
- 1.4 Гэрээ нь талууд харилцан гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хучин төгөлдөр болж, сангийн нэгж эрх нь Биржийн бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болно.
- 1.5 Энэхүү гэрээнд хэрэглэгдсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
  - 1.5.1 "Биржийн журам, заавар" гэж Биржийн үнэт цаасны бүртгэл, арилжаа, хяналт шалгалт, мэдээлэл, гишүүнчлэлийн асуудлыг зохицуулсан Биржээс гаргасан дүрэм, журам, заавар, аргачлалыг;
  - 1.5.2 "Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл" гэж өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ цацдаг радио, телевиз, сангийн болон хөрөнгийн биржийн цахим хуудсыг;
  - 1.5.3 "Олон нийтэд мэдээлсэн" гэж мэдээллийг хоёроос доошгүй олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглан нийтэлснийг.

## Хоёр. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС

- 2.1 Сан нь Биржид дараах хөлсийг төлнэ. Үүнд:
  - 2.1.1 Өргөдлийг хүлээн авч хянах үйлчилгээний хөлс - 2,000,000 /хоёр сая/ төгрөг;
  - 2.1.2 Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс – Дотоодын зах зээлд арилжаагддаг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах сангийн хувьд Нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 0.03 хувь, Хорооноос зөвшөөрсөн гадаадын арилжаа эрхлэх байгууллага дээр арилжаалагддаг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах сангийн хувьд Нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 0.05 хувь, хамгийн багадаа 2,000,000 төгрөг, хамгийн ихдээ 20,000,000 төгрөг.
  - 2.1.3 Жилийн үйлчилгээний хөлс - Сангийн цэвэр активын жилийн дундаж дүнгийн 0.025 хувь, хамгийн багадаа 2,500,000 төгрөг, хамгийн ихдээ 25,000,000 төгрөг байна.
- 2.2 Гэрээний 2.1.1-т заасан төлбөрийг Биржид хүсэлт гаргахаас өмнө төлсөн байх бөгөөд буцаан олгогдохгүй.
- 2.3 Гэрээний 2.1.2-т заасан төлбөрийг хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэхээс 3 өдрийн дотор Биржийн дансанд шилжүүлнэ.
- 2.4 Гэрээний 2.1.3-т заасан төлбөрийг тухайн оны нэгдүгээр улиралд багтаан Биржийн дансанд шилжүүлнэ.

- 2.5 Гэрээний 2.1.3-т заасан үнэлгээг тухайн нэгж эрхийн өнгөрсөн оны сүүлийн сарын дундаж үнэ цэнээр тооцно.
- 2.6 Нэгж эрх бүртгэлээс хасагдах тохиолдолд тухайн жилийн бүртгэлтэй байх хоногт хувь тэнцүүлэн жилийн үйлчилгээний хөлсийг төлж болно.
- 2.7 Нэгж эрхийн арилжааг зогсоосон нь жилийн үйлчилгээний хөлс төлөхгүй байх үндэслэл болохгүй.

Гурав. БИРЖИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1 Бирж нь дараах эрх эдэлнэ. Үүнд:

- 3.1.1 Нэгж эрхийн арилжаанд хяналт тавих, тодорхой чиглэл удирдамжийн дагуу шалгалт хийх;
- 3.1.2 Нэгж эрх эзэмшигчдийн эрх ашгийг хөндсөн асуудлаар сангаас гаргасан аливаа шийдвэр нь хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд шалгалт хийх;
- 3.1.3 Шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг сангаас гаргуулан авах;
- 3.1.4 Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хөндсөн аливаа асуудлаар сангаас тайлбар, тодруулга шаардан авах;
- 3.1.5 Сангаас ирүүлсэн мэдээ, мэдээллийг олон нийтэд мэдээлэх, санд мэдээллийг олон нийтэд хүргэх талаар шаардлага тавих;
- 3.1.6 Сан нь үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомжийг зөрчсөн, Биржээс тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд олон нийтэд мэдээлэх;
- 3.1.7 Санд үзүүлсэн үйлчилгээний хөлсийг гэрээний 2 дугаар зүйлд заасны дагуу шаардах;
- 3.1.8 Санг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасан нийтлэг үүргээ биелүүлэн ажиллах талаар шаардлага тавих;
- 3.1.9 Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Сангийн бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагаанд холбогдох журам, удирдамжийн дагуу тусгай шалгалтыг хийх;
- 3.1.10 Сан нь холбогдох хууль, дүрэм, журам зөрчсөн тохиолдолд эрх хэмжээнийхээ хүрээнд Биржийн "Хамтын Биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам", Хяналтын журам, энэ гэрээний дагуу хариуцлага тооцох;
- 3.1.11 Хууль, журамд заасан бусад эрх.

3.2 Бирж нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- 3.2.1 Сангийн гаргасан нэгж эрхийг нэгж эрхийн бүртгэлд бүртгэж, нэгж эрхийн арилжааг зохион байгуулах ажиллагааг зохих дүрэм, журмын дагуу хийж гүйцэтгэх;
- 3.2.2 Сангийн хүсэлтээр хөрөнгийн зах зээлтэй холбоотой асуудлаар зохих журам, шийдвэрийн хүрээнд зөвлөгөө, зааварчилгаа өгөх, сургалт, семинар зохион байгуулах;
- 3.2.3 Сантай холбоотой Биржийн журам, зааварт өөрчлөлт орсон нөхцөлд энэ талаар болон шаардлагатай мэдээллийг санд өөрийн цахим хуудсаар мэдэгдэх;
- 3.2.4 Сангийн нэгж эрхийн бүртгэл, арилжаатай холбоотой мэдээ, судалгааг зохих журмын дагуу Сангийн хүсэлтээр гаргаж өгөх;
- 3.2.5 Сангаас олон нийтэд мэдээлэхээр ирүүлсэн үйл ажиллагааны талаарх мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан мэдээлэх.

Дөрөв. САНГИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Сан нь дараах эрх эдэлнэ. Үүнд:

- 4.1.1 Нэгж эрх бүртгүүлэх, бүртгэлээс хасуулах тухай өргөдөл гаргах;
- 4.1.2 Бүртгэгдсэн нэгж эрхийг Хорооны зөвшөөрлийн дагуу анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаанд оруулах хүсэлт гаргах;
- 4.1.3 Сан нь нэгж эрх эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурал хуралдуулах, үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулхатай холбоотой асуудлаар Биржээс заавар, зөвлөмж авах;
- 4.1.4 Нэгж эрхийн бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Биржид санал хүсэлт гаргах, журамд заасан хугацаанд үндэслэл бүхий хариу авах, шийдвэрлэх асуудлаар харилцан зөвшилцэх;
- 4.1.5 Холбогдох дүрэм, журамд заасан нөхцөлийг хангасан тохиолдолд нэгж эрхийн бүртгэл, арилжаатай холбогдох мэдээлэл, судалгааг авах;
- 4.1.6 Сантай холбоотой Биржээс гаргасан шийдвэрийн талаар аливаа гомдлоо Хороонд гаргах.

**4.2 Сан нь дараах үүрэгтэй. Үүнд:**

- 4.2.1 Сан нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасан нийтлэг үүрэг болон Биржийн "Хамтын Биржээр арилжаалагдаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ын 3 болон 4 дүгээр зүйлд заасан үүргийг бүртгэлтэй байх хугацаандаа биелүүлж ажиллах;
- 4.2.2 Сан нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хууль, Хороо, Биржийн журам, заавруудыг дагаж мөрдөх, хууль, журмын хүрээнд Биржээс тавьсан шаардлагыг биелүүлж ажиллах;
- 4.2.3 Бирж, түүний нэгж эрхийн бүртгэл болон хяналт хариуцсан ажилтнаас тавьсан шаардлагыг биелүүлэх, мэдээ, судалгаа, тайлбар, тодруулгыг гаргаж өгөх, нэгж эрх худалдах замаар хуримтлуулсан хөрөнгийн зарцуулалттай холбоотой асуудлын хүрээнд шалгуулах;
- 4.2.4 Өөрийн нэгж эрх эзэмшигч, хөрөнгө оруулагчдад шударга, тэгш хандах;
- 4.2.5 Дотоодод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг байх, хэрэв мөрддөггүй бол энэ тухай тайлбар гаргаж Биржид мэдэгдэх ба олон нийтэд мэдээлэх;
- 4.2.6 Сан нь хөрөнгө оруулагчдад болон Биржид мэдээлэл хүргэх талаар дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
  - 4.2.6.1 Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль, журмын дагуу хөрөнгө оруулагчдад хүргэхээр заасан мэдээллийг тогтоосон хугацаанд гаргаж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэх ба Биржид мэдэгдэх;
  - 4.2.6.2 Мэдээлэл түгээхтэй холбоотой журам, зааварт тусгасан мэдээллийг заасан хугацаанд цахим болон хэвлэмэл хэлбэрээр Биржид хүргүүлэх;
  - 4.2.6.3 Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн тавдугаар бүлэгт тусгасан анхдагч болон хоёрдогч зах зээлийн мэдээллийг Хороо, Биржид бичгээр болон цахим хэлбэрээр хүргэх, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэх;
  - 4.2.6.4 Нэгж эрхийн үнэ ханшид нөлөөлж болох, үнэт цаасны арилжаанд оролцоход давуу тал олгох нийтэд тараагдаагүй мэдээллийг хөрөнгө оруулагч бусад этгээдэд нэгэн зэрэг, тэгш хүргэх;
  - 4.2.6.5 Нэгж эрхийн ханшид нөлөөлөх аливаа мэдээллийг дараа өдрийн арилжаанаас өмнө олон нийтэд мэдээлж, энэ тухай Биржид мэдэгдэх;
  - 4.2.7 Гэрээний 2 дугаар зүйлд заасан хөлсийг тогтоосон хугацаанд төлөх;
  - 4.2.8 Үнэт цаасны зах зээл дээр мөрдөгдөж буй хууль, дүрэм, журам, заавар, гэрээний үүргийн биелэлтэй холбогдуулан Биржээс тавьсан шаардлагыг биелүүлж хариу мэдэгдэх;
  - 4.2.9 Биржээс тавьсан хууль ёсны шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд энэ тухай шалтгаан бүхий тайлбарыг Биржид нэн даруй бичгээр хүргүүлэх;
  - 4.2.10 Гэрээний 4.2.9-д заасны дагуу тайлбар ирүүлээгүй нөхцөлд шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

**Тав. ХАРИУЦЛАГА**

- 5.1 Сан нь гэрээний 4.2-д заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд Биржийн зүгээс хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд олгогдсон эрх хэмжээний дагуу арга хэмжээ авна.

- 5.2 Мэдээллийн үнэн зөвийг мэдээлэл гаргагч талууд хариуцна.
- 5.3 Сан нь гэрээний 4.2.6.2-т заасан үүргээ зөрчсөн тохиолдолд Иргэний хуулийн 232.5-д заасны дагуу мэдээний төрөл бүрт 100 000 төгрөгийн анзыг Биржид төлнө.
- 5.4 Сан нь энэхүү гэрээний 2 дугаар зүйлд заасан үйлчилгээний хэлсийг заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд хугацаа хожимдуулсан хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дунгийн 0.5 хувиар тооцож алданги нэмж төлнө.
- 5.5 Сангийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан нэгж эрхийг арилжааг зогсоо болон бусад арга хэмжээтэй холбогдон нэгж эрх эзэмшигч, бусад этгээдэд учирсан хохирлыг Бирж хариуцахгүй.
- 5.6 Нэгж эрхийн танилцуулга, холбогдох баримт бичигт худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, зөрүүтэй, алдаатай мэдээлэл тусгасны улмаас бусдад хохирол учруулсан бол уг хохирлыг холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу сан, уг шийдвэрийг гаргасан эрх бүхий албан тушаалтан хамтран хариуцна.

#### Зургаа. БУСАД

1. Гэрээ гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
2. Талуудын хүсэлтээр харилцан тохиролцож гэрээнд өөрчлөлт оруулж болно.
3. Энэхүү гэрээний зарим заалт нь хуулиар хүчин төгөлдөр бусд тооцогдох бол уг заалтыг оролцуулахгүйгээр гэрээг хүчин төгөлдөр хэвээр үргэлжлүүлэхийг талууд хүлээн зөвшөөрсөн болно.
4. Талуудын хооронд гарсан маргаантай асуудлыг харилцан зөвшилцэж шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд зөвшилцөлд хүрч чадахгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Биржийг төлөөлж:

Гүйцэтгэх Захирал

/ ..... /

Санг төлөөлж:

“.....” -ийн

/ ..... /



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 10 сарын 27 өдөр

дугаар 37

Улаанбаатар хот

Г Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын  
сангийн нэгж эрхийн бүртгэлийн журамд  
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.3, 49 дүгээр зүйлийн 49.1.2, 49.1.4, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалтууд, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 5.7.22 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 тоот тогтоолоор батлагдсан "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-д энэхүү тогтоолын хавсралтаар нэмэлт, өөрчлөлт оруулсугай.
2. Журамд орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар Санхүүгийн зохицуулах хороонд танилцуулж, батламжлуулахыг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д үүрэг болгосугай.
3. Журмын нэмэлт, өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хороо батламжилсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Н.Улаанхүү/-нд үүрэг болгосугай.



Д.ТОГТОХБАЯР

1502215108

## ТӨСӨЛ


Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын  
сангийн нэгж эрхийн бүртгэлийн журамд  
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.3, 49 дүгээр зүйлийн 49.1.2, 49.1.4, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалтууд, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 5.7.22 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 тоот тогтоолоор батлагдсан "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-д оруулсан нэмэлт өөрчлөлтийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Журамд орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар Санхүүгийн зохицуулах хороонд танилцуулж, батламжлуулахыг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д үүрэг болгосугай.
3. Журмын нэмэлт, өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хороо батламжилсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Н.Улаанхүү/-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Д.ТОГТОХБАЯР



**“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН  
“ХАМТЫН ХААЛТАЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
САНГИЙН НЭГЖ ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН ЖУРАМ”**

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 37 тоот  
тогтоолын хавсралтаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/*

# **“ХАМТЫН ХААЛТТАЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН ЖУРАМ”**

## **Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1 Энэхүү журмын зорилго нь хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх /цаашид “нэгж эрх” гэх-/ийг Монголын хөрөнгийн бирж /цаашид “Бирж” гэх-/ийн нэгж эрхийн бүртгэлд бүртгэх, бүртгэлийн шалгуурыг тогтоох, нэгж эрхийг нийтэд танилцуулах, бүртгэлд өөрчлөлт оруулах, арилжааг түр зогсоох, сэргээх, бүртгэлээс хасах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шударга, ил тод, шуурхай явуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 37 тоот тогтооолоор нэмэлт оруулсан/*

- 1.2 Энэхүү журмыг Биржийн нэгж эрхийн бүртгэлд бүртгэгдсэн, бүртгүүлэхээр хүсэлт гаргасан хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан /цаашид “Сан” гэх/, түүний үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани /цаашид “үүсгэн байгуулагч” гэх/, Төлөөлөн Удирдах Зөвлөл /цаашид “ТҮЗ” гэх-/ийн гишүүн болон бусад эрх бүхий албан тушаалтан, аудитор, хуульч, хөрөнгийн үнэлгээчин болон холбоотой бусад этгээд дагаж мөрдөнө.
- 1.3 Журамд хоёрдмол утга гарсан тохиолдолд, Бирж нь журмыг тайлбарлах эрхтэй байна.
- 1.4 Хамтын биржээр арилжаалагддаг сангийн нэгж эрхийг бүртгэхтэй холбоотой харилцааг тусгайлсан журмаар зохицуулна.

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 37 тоот тогтооолоор нэмсэн/*

**Хоёр. Нийтэд санал болгон анх удаа гаргах хамтын хаалттай хөрөнгө  
оруулалтын сангийн нэгж эрхийг биржийн бүртгэлд бүртгэх,  
бүртгэлд өөрчлөлт оруулах**

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 37 тоот тогтооолоор нэмэлт оруулсан/*

- 2.1 Нэгж эрх бүртгүүлэх тухай өргөдөл, нэгж эрхийн танилцуулгад үүсгэн байгуулагчийн ТҮЗ-ийн дарга, Гүйцэтгэх захирал гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан байна. Нэгж эрх бүртгүүлэх хүсэлтэд дараах бичиг баримтыг хавсаргана:
  - 2.1.1 Нэгж эрх бүртгүүлэх өргөдөл /Маягт 1/;
  - 2.1.2 Нэгж эрх гаргагч Сангийн мэдэгдэл /Маягт 2/;
  - 2.1.3 Нэгж эрх олон нийтэд санал болгон худалдах үйл ажиллагаанд андеррайтер оролцох тохиолдолд андеррайтерийн мэдэгдэл /Маягт 3/;
  - 2.1.4 Нэгж эрх гаргах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр;
  - 2.1.5 Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлсэн нэгж эрхийн танилцуулга;
  - 2.1.6 Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;
  - 2.1.7 Сангийн дүрмийн хуулбар,

- 2.1.8 Сангийн эхлэлтийн санхүүгийн тайлан;
  - 2.1.9 Сангийн бизнес төлөвлөгөө, холбогдох судалгааны тайлан;
  - 2.1.10 Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг;
  - 2.1.11 Хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний гэрээний хуулбар;
  - 2.1.12 Кастодиан банктай байгуулсан гэрээний хуулбар;
  - 2.1.13 Сангийн багц дүрэм, журмууд /Сангийн нэгж эрхийг үнэлэх дотоод журам; Нэгж эрх эзэмшигчдэд мэдээлэл хүргэх журам; Хөрөнгө итгэмжлэн удирдах журмын төсөл, эрсдлийн удирдлагын журмын төсөл, дотоод хяналтын үйл ажиллагааны журмын төсөл, татан буулгах ажиллагааны журмын төсөл/;
  - 2.1.14 Сангийн үүсгэн байгуулагч, кастодиан банк, аудитор зэрэг байгууллагуудын дэлгэрэнгүй мэдээлэл;
  - 2.1.15 Сангийн гүйцэтгэх удирдлага болон мэргэжилтнүүд Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх-/ноос тогтоосон шаардлагуудыг хангаж байгааг нотлох баримт;
  - 2.1.16 Хөрөнгө итгэмжлэн удирдах менежментийн компанийн дүрэм, санхүүгийн тайлан;
  - 2.1.17 Хөрөнгө оруулалтын санг нэгээс дээш тооны хөрөнгө оруулалтын менежментийн компани хамтран үүсгэн байгуулж байгаа тохиолдолд тэдгээрийн хооронд байгуулсан гэрээний хувь;
  - 2.1.18 Энэ журмын 6 дугаар зүйлд заасан өргөдөл хүлээн авах, хянах үйлчилгээний хөлс төлсөн баримт.
  - 2.1.19 Биржээс шаардлагатай гэж үзсэн бусад бичиг баримт.
- 2.2 Нэгж эрхийн танилцуулгад Хорооны “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг тусгасан байна:
- /Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 37 тоот тогтоогоор өөрчлөлт оруулсан/*
- 2.2.1 Нэгж эрхийг олон нийтэд санал болгон худалдах, нэгж эрхийг хуваарилах нөхцөл;
  - 2.2.2 Нэгж эрхийн цэвэр хөрөнгийн үнэлгээг тооцоолох, мэдээлэх нөхцөл, журам;
  - 2.2.3 Хөрөнгө оруулагчаас нэгж эрх эзэмшихтэй холбогдон гарах нийт зардлын бүтэц, хэмжээг харуулсан дэлгэрэнгүй мэдээлэл /Маягт 4/;
  - 2.2.4 Танилцуулгын эхний хуудсанд дараах анхааруулгыг тодоор бичсэн байна:  
“Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг Монголын Хөрөнгийн Бирж бүртгэсэн нь уг нэгж эрхийн эрсдлийн талаар аливаа баталгаа гаргаагүй болохыг анхаарах нь зүйтэй. Үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани болон түүний удирдаж байсан бусад сангийн үйл ажиллагааны түүхэн гүйцэтгэл нь энэхүү нэгж эрхийг гаргаж буй сангийн ирээдүйн гүйцэтгэлийн баталгаа болохгүй. Энэхүү нэгж эрхийг худалдан авах

замаар хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагч Таны хувьд ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ үйлдэл байдгийг онцгойлон анхаарч, нэгж эрхийн танилцуулга, нэгж эрх гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.”

2.3 Нэгж эрхийн танилцуулгад Сангийн Гүйцэтгэх захирал гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан байх бөгөөд “Биржид ирүүлж байгаа танилцуулга нь Хороонд хүргүүлж байгаа танилцуулгатай адил, ямар нэг зөрүүтэй мэдээлэл тусгагдаагүй болно” гэсэн баталгаа гаргасан байна;

2.4 Сан нь энэ журамд заасны дагуу өргөдөл болон хавсаргах бичиг баримтыг зохих шаардлагын дагуу бүрдүүлж, хэвлэмэл хэлбэрээр эх хувийг Биржид хүргүүлнэ.  
*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 37 тоот тогтоогоор өөрчлөлт оруулсан/*

2.5 Биржийн үнэт цаасны бүртгэлд бүртгэгдсэн Сан нь нэгтгэх, нийлүүлэх замаар өөрчлөн байгуулагдсан тохиолдолд үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах бөгөөд бүртгэлд өөрчлөлт оруулах тухай хүсэлтийг Хороонд хүргүүлсэн баримт бичгийн хамт Биржид ирүүлнэ.

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 37 тоот тогтоогоор өөрчлөлт оруулсан/*

2.6 Бирж нь сангийн нэгж эрхийг бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулах асуудлаар хийгдсэн шалгалтын тайланд үндэслэн, нэгж эрхийг бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулах эсэх асуудлыг Бүртгэлийн хорооны хурлаар шийдвэрлэж, Гүйцэтгэх захирал тушаал гаргах бөгөөд тушаалын хувийг холбогдох мэдэгдлийн хамт Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад хүргүүлнэ.

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 37 тоот тогтоогоор өөрчлөлт оруулсан/*

2.7 Бирж нь сангийн нэгж эрхийг бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулах өргөдөл хүсэлтийг хянан шалгах ажиллагааг зохион байгуулах, бүртгэхээс татгалзах тухай шийдвэр гаргахдаа Биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 8 дугаар зүйлийг баримтална.

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 37 тоот тогтоогоор өөрчлөлт оруулсан/*

#### **Гурав. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн шалгуур, шаардлага**

3.1 Сан нь Биржид бүртгүүлэхэд болон бүртгэлтэй байх хугацаанд энэ журамд заасан шалгуурыг хангаж ажиллана.

3.2 Биржийн бүртгэлд бүртгүүлэх нэгж эрх гаргагч Сан нь дараах шалгуурыг хангасан байна:

- 3.2.1 Нэгж эрхийн танилцуулгыг боловсруулж, Хороонд бүртгүүлсэн байх;
- 3.2.2 Гүйцэтгэх удирдлага болон мэргэжилтнүүд нь Хорооны тохиромжтой этгээдийн шаардлагыг хангасан байх;
- 3.2.3 Кастодианы болон хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг байгуулсан байх;
- 3.2.4 Сангийн цэвэр хөрөнгийн үнэ цэнийг тооцоолох, олон нийтэд тогтмол мэдээлэх программ хангамж, цахим хуудастай байх;

3.2.5 Арилжааны төлбөр тооцоо нь холбогдох эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй этгээдээр дамжин хийгдэх нөхцлийг хангасан байх.

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 37 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

### **Дөрөв. Сангийн бүртгэлтэй байх хугацаанд биелүүлэх үүрэг**

4.1 Сан нь Монгол Улсын үнэт цаасны зах зээл дээр мөрдөгдөж буй хууль, тогтоомж, журам, заавар, Биржтэй байгуулсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн гэрээ /цаашид “гэрээ” гэх/-нд туссан хөрөнгө оруулагчдын болон эрх бүхий байгууллагын өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ажиллана.

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 37 тоот тогтоолоор нэмэлт оруулсан/*

4.2 Сан нь бүртгэлтэй байх хугацаандаа энэхүү журамд заасан шалгуурыг хангаж ажиллахаас гадна дараах үүргийг биелүүлж ажиллана:

4.2.1 Хорооны “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам” /цаашид “Хорооны журам” гэх/-д заасан сангийн үйл ажиллагаа, актив, хөрвөх чадварт тавигдах шалгуур, шаардлагыг хангаж ажиллах;

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 37 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

4.2.2 Батлагдсан хөрөнгө оруулалтын бодлогыг нягт баримталж ажиллах, бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулахдаа нэгж эрх эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх;

4.2.3 Сангийн нийт гаргасан нэгж эрхийн 25-аас доошгүй хувь олон нийтэд чөлөөтэй арилжигддаг байх, нэгж эрх эзэмшигчдийн тоо 50-аас доошгүй байх;

4.2.4 Нэгж эрх эзэмшигчидтэй харилцах алба, нэгж, байнгын ажлын байртай байх ба хөрөнгө оруулагчдад хууль тогтоомжийн дагуу мэдээ, мэдээлэл өгөх утас, цахим хуудсыг тогтмол ажилууллах;

4.2.5 Сангийн цэвэр хөрөнгийн үнэ цэнийг өөрийн цахим хуудас болон Биржийн цахим хуудсаар дамжуулан өдөр бүр Биржийн арилжаа явагдаж дууссанаас хойш 21 цагийн дотор буюу дараагийн өдрийн арилжаа эхлэхээс 1 цагийн өмнө нийтэд мэдээлэх;

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 37 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

4.2.6 Сангийн цэвэр хөрөнгийн өөрчлөлт, хэрэгжсэн болон хэрэгжээгүй ашиг, алдагдлын тооцоолол, удирдлагын зардал, сангийн нэгж эрх эзэмшигчид төлсөн ногдол ашиг, сангийн хөрөнгийн дэлгэрэнгүй бүтэц зэрэг мэдээллийг агуулсан сангийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн жилийн тайланг Хөрөнгө Оруулалтын Гүйцэтгэлийг Үнэлэх Олон Улсын Стандарт /GIPS/-ын дагуу гаргаж, Сангийн жилийн үйл ажиллагааны тайланд хавсаргах, улирал тутмын мэдээллийг энэ журмын Маягт-5-ын дагуу гаргаж, дараа сарын 10-ны өдрийн дотор Биржид ирүүлэх, заасан хугацаанд олон нийтэд мэдээлэх;

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 37 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

4.2.7 Сангийн жилийн болон хагас жилийн үйл ажиллагааны тайланг Хорооны холбогдох журамд заасны дагуу гаргаж, жилийн үйл ажиллагааны тайланг аудитлагдсан санхүүгийн тайлангийн хамт дараа жилийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор, хагас жилийн үйл ажиллагааны тайланг санхүүгийн тайлангийн хамт 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор Биржид ирүүлж, олон нийтэд мэдээлэх;

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 37 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

4.2.8 Сангийн нийт гаргасан нэгж эрхийн 5 ба түүнээс дээш хувийг эзэмшиж буй нөлөө бүхий этгээдийн эзэмшиж буй нэгж эрхийн тоо, хувь хэмжээнд өөрчлөлт гарсан тухай бүр Биржид мэдэгдэж, олон нийтэд мэдээлэх;

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 37 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

4.2.9 Сангийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, дүрэм, журам, эрх бүхий албан тушаалтан, холбоо барих хаяг, байршил, утас, хөрөнгө оруулалтын менежментийн компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц зэрэгт өөрчлөлт орсон тохиолдолд өөрчлөлтийг тухай бүр Биржид бичгээр мэдэгдэх;

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 37 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

4.2.10 Эрх бүхий байгууллагаас санд авсан арга хэмжээний талаар тухай бүр Биржид бичгээр мэдэгдэх;

4.2.11 Ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд ногдол ашгийн хэмжээ, төлөх өдөр, бүртгэх өдрийн талаар тухай бүр мэдээлэл ирүүлэх;

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 37 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

4.2.12 Нэгж эрх эзэмшигчдийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг тухай бүр ирүүлэх, олон нийтэд мэдээлэх;

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 37 тоот тогтоолоор нэмсэн/*

4.2.13 Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан бусад мэдээллийг тухай бүр ирүүлэх;

4.2.14 Бүртгэлтэй байх хугацаандаа жилийн үйлчилгээний хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлөх.

#### **Тав. Нэгж эрхийн арилжааг түр зогсоох, бүртгэлээс хасах**

5.1 Нэгж эрхийн арилжааг зогсоохдоо Хорооны Улсын байцаагчийн шийдвэрийг үндэслэх ба дараах тохиолдлуудад арилжааг түр зогсоох тухай саналыг Хороонд хүргүүлнэ. Үүнд:

5.1.1 Сан нь тогтмол биелүүлэх үүргээ биелүүлээгүйгээс хөрөнгө оруулагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүссэн;

5.1.2 Цэвэр хөрөнгийн хэмжээ нь дараалсан 10 хоногийн туршид тухайн сан үйл ажиллагаагаа эхлүүлсэн өдрийн хэмжээнээс 40 хувь ба түүнээс дээш хэмжээгээр буурсан;

5.1.3 Хөрөнгө оруулалтын менежментийн компани татан буугдах, эсвэл түүний хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл түдгэлзсэн, цуцлагдсан, эсвэл кастодиан татан буугдах, дампуурах нөхцөл байдал бий болсны улмаас холбогдох гэрээний эрх, үүргийг эрх бүхий өөр этгээдэд шилжүүлэх шаардлага үүссэн;

5.1.4 Хөрөнгө оруулалтын сангийн бусдын өмнө хүлээсэн төлбөрийн үүрэг нь тухайн сангийн цэвэр хөрөнгийг сангийн нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн доод хэмжээнээс болон дараалсан 10 хоногийн туршид тухайн сан үйл ажиллагаагаа эхлүүлсэн өдрийн хэмжээнээс 40 хувь ба түүнээс дээш хэмжээгээр буурах нөхцөл байдал үүссэн;

5.1.5 Хөрөнгө оруулагчдын эрх ашигт сэргээр нөлөөлөх бусад нөхцөл байдал.

5.2 Тухайн сангийн нэгж эрхийг Сангийн хүсэлтээр Биржийн нэгж эрхийн бүртгэлээс хасахаас гадна дараах тохиолдлуудад үнэт цаасны бүртгэлээс хасна. Үүнд:

5.2.1 Тогтол биелүүлэх үүргээ удаа дараа биелүүлээгүй;

5.2.2 Энэхүү журмын 5 дугаар зүйлийн 5.1-д заасан үндэслэлээр нэгж эрхийн арилжаа зогсоноос хойш зургаан сарын хугацаанд зөрчил, эсхүл үүссэн нөхцөл байдал арилаагүй;

5.2.3 Сангийн нэгж эрх эзэмшигчдийн шийдвэрээр санг нэгтгэх, нийлуулэх замаар өөрчлөн байгуулахаар болсон;

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 37 тоот тогтооолоор өөрчлөлт оруулсан/

5.2.4 Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа явуулах хугацаа дуусгавар болсон;

5.2.5 Хөрөнгө оруулалтын сан дампуурсан;

5.2.6 Хууль тогтоомж, Хорооны журамд заасан бусад үндэслэл.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 37 тоот тогтооолоор өөрчлөлт оруулсан/

5.3 Нэгж эрхийн арилжааг дараах тохиолдолд сэргээх тухай Хороонд мэдэгдэл хүргүүлнэ. Үүнд:

5.3.1 Сан нь гаргасан зөрчлөө арилгасан тухайгаа мэдэгдсэн, эсхүл Биржээс уг зөрчлийг арилсан гэж тогтоосон;

5.3.2 Зохицуулах эрх бүхий байгууллага, шүүх хяналтын байгууллагаас Санд авсан арга хэмжээг үндэслэлгүй гэж үзсэн;

5.3.3 Хууль тогтоомж, дүрэм, журамд заасан бусад үндэслэл.

### **Зургаа. Үйлчилгээний хөлс**

6.1 Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49.3-т заасны дагуу Бирж нь нэгж эрх бүртгүүлэх өргөдлийг хянан шийдвэрлэж, нэгж эрхийг Биржийн бүртгэлд бүртгэх, нэгж эрхийг нийтэд санал болгон худалдах, худалдан авахтай холбоотой гэрээ, хэлцэл байгуулах нөхцлийг бүрдүүлэх, нэгж эрхийн арилжааг зохион байгуулах

үндсэн чиг үүргийнхээ хүрээнд Сананд үзүүлж байгаа үйлчилгээнийхээ хөлсийг тогтоон авах эрхтэй.

## 6.2 Сананд Биржээс үзүүлэх үйлчилгээний хөлс нь дараах төрөлтэй байна:

6.2.1 Бүртгүүлэх өргөдөл хүлээн авч хянах үйлчилгээний хөлс – 2,000,000 төгрөг;

6.2.2 Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс – Нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 0.25% байх ба хамгийн багадаа 25,000,000 төгрөг, хамгийн ихдээ 100,000,000 төгрөг;

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 37 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

6.2.3 Жилийн үйлчилгээний хөлс – Сангийн цэвэр хөрөнгийн дүнгийн 0.025%, хамгийн багадаа 2,500,000 төгрөг, хамгийн ихдээ 50,000,000 төгрөг байна.

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 37 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

## Долоо. Хариуцлага

7.1. Сан, түүний эрх бүхий албан тушаалтан болон хамтран ажиллаж буй мэргэжлийн байгууллага нь энэхүү журам болон бусад холбогдох дүрэм, журмыг зөрчсөн, эсхүл хэрэгжүүлээгүй тохиолдолд энэ журам болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

7.2. Сан нь Биржээс үзүүлэх жилийн үйлчилгээний хөлсийг гэрээнд заасан хугацаанд тогтоосон хэмжээгээр төлөөгүй бол хугацаа хожимдуулсан хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар тооцож алданги нэмж төлнө.

7.3. Сан нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг хэрхэн мөрдөж байгаад энэхүү журмын 8.2-д заасны дагуу Биржээс хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар Сан, түүний холбогдох этгээдэд шаардлага хүргүүлж, журам болон гэрээний дагуу хариуцлага ногдуулж болно.

7.4. Сан, түүний эрх бүхий албан тушаалтан болон холбогдох этгээдэд дараах хэлбэрийн хариуцлагыг хамтад нь, эсхүл тус тусад нь тооцно.

7.4.1 Сануулах;

7.4.2 Гэрээний хариуцлага ногдуулах;

7.4.3 Нэгж эрхийн арилжааг зогсоо тухай мэдэгдэл Хороонд хүргүүлэх;

7.4.4 Нэгж эрхийг бүртгэлээс хасах.

7.5 Ногдуулах хариуцлагын хэлбэрийг сонгоходоо Бирж нь Сан, түүний эрх бүхий албан тушаалтан болон холбогдох этгээдийн гаргасан зөрчлийн шинж чанар, гэм буруутай байдлыг харгалзаж үзнэ.

7.6 Нэгж эрхийн танилцуулга, холбогдох баримт бичгийг бэлтгэхэд оролцсон этгээд өөрийн гүйцэтгэсэн ажилтай холбоотойгоор бусдад учруулсан хохирлыг тус бүртээ хариуцна.

## **Найм. Бусад**

8.1 Сан нь Биржээс Сантай холбоотой буюу Биржид бүртгэлтэй нэгж эрхтэй холбоотойгоор гаргасан аливаа шийдвэрийг эс зөвшөөрвэл шийдвэрийг гардан авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор Хороонд гомдол гаргаж болно.

8.2 Биржийн хяналт шалгалт хариуцсан алба Сангийн үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, журам, заавар, гэрээний үүргийн биелэлтэд хяналт шалгалтын холбогдох журамд заасны дагуу зайны хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд газар дээрх шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулна.

-00-

## БҮРТГЭЛИЙН ӨРГӨДЛИЙН МАЯГТ

Хэнд: “Монголын хөрөнгийн бирж” ХК,  
Бүртгэлийн алба

Огноо: .....

Эрхэм Танаа,

Бид ..... [Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан, түүнийг төлөөлж] энэхүү маягтын 2-т тусгасан нэгж эрхийг Санхүүгийн Зохицуулах Хорооны “Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам” болон “Монголын Хөрөнгийн Бирж” ХК /цаашид “Бирж” гэх/-ийн “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын дагуу бүртгүүлж, арилжаалах зөвшөөрөл авахаар энэхүү өргөдлийг гаргаж байна.

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 37 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

### I. Сангийн мэдээлэл:

1	Сангийн оноосон нэр:	
2	Хөрөнгө оруулалтын хэрэгслүүд:	
3	Хөрөнгө оруулалтын удирдлагын хэлбэр /идэвхтэй, идэвхгүй/:	
4	Үйл ажиллагаа явуулах хугацаа:	
5	Бүртгэлтэй улс, улсын бүртгэлийн дугаар:	
6	Регистерийн дугаар:	
7	Үүсгэн байгуулагдсан огноо:	
8	Үйлчилгээний зардлын хувь хэмжээ:	
9	Оршин байх албан ёсны хаяг: /Монгол Улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ/	
10	Хөрөнгө оруулагч, нэгж эрх эзэмшигчдэд мэдээлэл өгөх цахим хуудасны хаяг:	
11	Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:	
12	Өргөдөлтэй холбоотой асуудлыг хариуцах этгээдийн нэр, албан тушаал, хаяг, холбоо барих утас:	

13	Нэгж эрхийн 5 болон түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшидэг нэгж эрх эзэмшигчийн талаарх мэдээлэл: /5 болон түүнээс дээш хувийг аж ахуйн нэгж эзэмшидэг бол түүний хяналтын багц эзэмшигч бенефициар ёмчлөгчийг мөн бичнэ/	
14	Нэгж эрхийн код /үсгэн ба тоон/ Шинээр үnэт цаас бүртгүүлэх компани нь үnэт цаасанд олгох үсгэн кодны саналаа бичнэ:	
15	Бүртгүүлэх нэгж эрхийн тоо ширхэг, нэрлэсэн үnэ, үnийн дүн:	
16	Нэгж эрх гаргах замаар нийтээс татан тевлөрүүлэхээр тооцсон хөрөнгийн хэмжээ:	
17	Нэгж эрхийг нийтэд санал болгох хувь хэмжээ, үnэ; арга хэлбэр:	
18	Нэгж эрхийг нийтэд санал болгон арилжихаар төлөвлөсөн хугацаа:	

## II. Санд мэргэжлийн зөвлөгөө өгсөн зохицуулалттай хуулийн этгээдийн мэдээлэл

1	Андеррайтер оролцсон бол түүний оноосон нэр:	
2	Бүртгэлтэй улс, улсын бүртгэлийн дугаар:	
3	Регистерийн дугаар:	
4	Эрх бүхий байгууллагаас олгосон энэхүү үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар, огноо: /Нотлох баримтыг хавсаргана/	
5	Оршин байх албан ёсны хаяг;	
6	Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:	
7	Хуулийн зөвлөгөө өгсөн компанийн оноосон нэр:	
8	Бүртгэлтэй улс, улсын бүртгэлийн дугаар:	
9	Регистерийн дугаар:	
10	Эрх бүхий байгууллагаас олгосон энэхүү үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар, огноо: /Нотлох баримтыг хавсаргана/	
11	Оршин байх албан ёсны хаяг:	
12	Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:	

Өргөдөл гаргасан:

1. Овог, нэр: .....

2. Овог, нэр: .....

Албан тушаал:  
“.....” .... -ийн  
ТУЗ-ийн дарга  
.....  
Гарын үсэг:  
(Тамга/тэмдэг)

Албан тушаал: Андеррайтерийн  
“.....” .... - ийн  
ТУЗ-ийн дарга  
.....  
Гарын үсэг:  
(Тамга/тэмдэг)

3. Овог, нэр: .....

Албан тушаал: Сангийн  
“.....” .... -ийн  
Гүйцэтгэх захирал  
.....  
Гарын үсэг:  
(Тамга/тэмдэг)

4. Овог, нэр: .....

Албан тушаал: Андеррайтерийн  
“.....” .... -ийн  
Гүйцэтгэх захирал  
.....  
Гарын үсэг:  
(Тамга/тэмдэг)

5. Овог, нэр: .....

Албан тушаал: Сангийн  
“.....” .... -ийн  
Ерөнхий нягтлан бодогч  
.....  
Гарын үсэг:  
(Тамга/тэмдэг)

6. Овог, нэр: .....

Албан тушаал: Хуулийн зөвлөгөө  
үзүүлэх “.....” .... -ийн  
Гүйцэтгэх захирал  
.....  
Гарын үсэг:  
(Тамга/тэмдэг)

### ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ /зөвхөн Биржийн албан хэрэгцээнд/

Өргөдөл хүлээн авсан ажилтны овог, нэр:	Өргөдөл хүлээн авсан огноо, цаг, минут:	Өргөдөл, түүнд хавсаргасан баримтын тоо /нүүрээр/:

## САНГИЙН МЭДЭГДЭЛ

Огноо .....

### I. Сангийн мэдэгдэл:

1. Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан ..... [сан, түүнийг төлөөлж] бид өөрсдийн мэдлэг чадвараа бүрэн ашиглан дараах ажиллагааг хийж гүйцэтгэсэн гэдгээ мэдэгдэж байна:
  - 1.1. "Монголын хөрөнгийн бирж" ХК /цаашид "Бирж" гэх/-ийн "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам" болон бусад хууль тогтоомжийн хүрээнд нэгж эрхийг гаргаж бүртгүүлэх, нийтэд санал болгох, танилцуулахтай холбоотой шаардагдах бүхий л баримт бичгийг үнэн зөвөөр бүрдүүлсэн.
  - 1.2. Нэгж эрх бүртгүүлэхтэй холбоотой Биржийн "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-д тусгагдсан нөхцөл шалгуурыг бүрэн хангасан.
  - 1.3. "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-д заасан болон хууль, тогтоомжоор шаардах бусад мэдээллийг өргөдлийн хамт хүргүүлж байгаа баримт бичигт тусгасан. Хэрэв сүүлчийн хувилбар хүргэгдээгүй бөгөөд мэдээлэл дутуу бол дутуу мэдээллийг тусгаж, залруулан хүргүүлнэ.
  - 1.4. Нэгж эрх бүртгүүлэх, бүртгэлд өөрчлөлт оруулах зөвшөөрөл авахтай холбоотойгоор өргөдөлд тусгасан мэдээлэлтэй зөрчилдөх ямар нэгэн баримт материал байхгүй болно. Хэрэв зөрчилдөх материал байх тохиолдолд Биржид нэн даруй мэдээлнэ.
  - 1.5. Худал, ташаа мэдээллийн улмаас үүсэх хариуцлагыг бид бүрэн хариуцна.
2. Сангийн нэгж эрх нь Биржид бүртгэлтэй байх хугацаанд дараах үйл ажиллагааг тогтмол авч хэрэгжүүлэхийг мэдэгдэж байна:
  - 2.1. Манай нэгж эрх Биржид бүртгэгдсэн нөхцөлд Биржийн "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам" болон бусад холбогдох журам, заавраар тогтоосон шалгуурыг хангаж ажиллах ба цаашид зохих дүрэм, журмыг баримталж ажиллана.
  - 2.2. Өргөдлийг хүлээн авч, нэгж эрхийг бүртгэх тухай шийдвэр гарсан тохиолдолд зохих хууль, журмын дагуу арилжааг эхлүүлэх хүсэлтээ Санхүүгийн Зохицуулах Хороо /цаашид "Хороо" гэх/ болон Биржид хүргүүлнэ.
  - 2.3. Бид "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам" болон бусад холбогдох хууль, дүрэм, журамтай танилцсан бөгөөд нэгж эрх бүртгэлтэй хэвээр байх эсэх нь одоо болон ирээдүйд хүчин төгөлдөр мөрдөгдөх хууль дүрэм журмыг хэрхэн дагаж мөрдөхөөс хамааралтай болохыг хүлээн зөвшөөрч байна.

### II. Сангийн гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл:

1. Би .....[сангийн гүйцэтгэх удирдлага] өөрийн эрх мэдлийн хүрээнд Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж болон Хороо, Биржийн холбогдох журам, зааврыг бүрэн дагаж, биелүүлэн ажиллана.
2. Дараах зүйлсийг Биржийн журамд заасан тогтоосон хугацаанд цаг алдалгүй хүргүүлнэ:

- 2.1. Биржийн зүгээс хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор болон зах зээлийн үйл ажиллагааг хэвийн хангах зорилгоор шаардсан мэдээлэл баримтыг хүргүүлэх,
- 2.2. Биржийн зүгээс “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор шаардсан тайлбар, баримт бичиг, мэдээллийг хүргүүлж, хамтран ажиллах,
- 2.3. Мөн өөрт шууд холбогдох асуудалд хариу тайлбар гаргаж өгөх,
3. Энэ журамд тодорхойлсон эрх бүхий албан тушаалтны шалгуур, нөхцлийг хангаж байгааг мэдэгдэж байна.
4. Би .... жилийн хугацаанд сангийн гүйцэтгэх удирдлагаар ажиллаж байгаа бөгөөд миний албан тушаал, холбогдох хаяг өөрчлөгдсөн тохиолдолд Биржид нэн даруй мэдэгдэнэ.
5. Нэгж эрх бүртгүүлэхээр хүргүүлж буй өргөдөл, түүний хавсралт материалд /нэгж эрхийн танилцуулга хамаарна/ орсон өөрийн тухай мэдээлэл нь бүгд үнэн зөв гэдгийг баталгаажуулж байна.
6. Энэхүү мэдэгдлийн 4, 5-т /дээрх заалтууд/ тусгасан мэдээллийг хугацаанд нь мэдэгдээгүй, буруу ташаа мэдээлэл хүргүүлсэн нь нотлогдвол түүнээс үүсэх хариуцлагыг хүлээнэ.

### **III. Биржээс үзүүлэх үйлчилгээний хөлстэй холбоотой мэдэгдэл:**

1. Бүртгүүлэх өргөдлийг хүлээн авч, хянах үйлчилгээний хэлс ..... төгрөгийг ... оны ... дугаар сарын ...—ны өдөр..... банкны ..... дансанд төлсөн нь үнэн болно. /Төлбөр төлсөн баримтын хуулбарыг хавсаргах/
2. Олон нийтэд санал болгон худалдах нэгж эрхийн үнэ тодорхой болсон тохиолдолд журамд заасан хугацаанд тогтоосон хувь хэмжээгээр нэгж эрхийг бүртгэх үйлчилгээний хөлсийг Биржид төлөхөө мэдэгдэж байна.
3. Хэрэв Бирж нь өргөдөл тусгасан нэгж эрхийг бүртгээгүй, бүртгэхээс татгалзсан тохиолдолд “өргөдлийг хүлээн авч, хянах үйлчилгээний хэлс” нь буцаан олгогдохгүй болохыг хүлээн зөвшөөрч байна.
4. Нэгж эрх нь бүртгэлтэй байх хугацаанд журмаар тогтоосон хувь хэмжээгээр, заасан хугацаанд нь жилийн үйлчилгээний хөлсийг төлөхөө мэдэгдэж байна.

**Баталгаажуулсан:**

Овог, нэр:

.....

Албан тушаал:

“.....” ... К-ийн

.....

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

**Баталгаажуулсан:**

Овог, нэр:

.....

Албан тушаал:

“.....” ... К-ийн

.....

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

# ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИЙН МЭДЭГДЭЛ

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 37 тоот тогтооолоор өөрчлөлт оруулсан/

Огноо: .....

Бид ..... [Хөрөнгө оруулалтын менежментийн компани /цаашид ХОМК гэх/, түүнийг төлөөлж] ..... байршилтай, "Монголын хөрөнгийн бирж" ХК /цаашид "Бирж" гэх/-ийн "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-д заасны дагуу ..... сангийн нэгж эрхийг олон нийтэд санал болгоход мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх бөгөөд журамд заасны дагуу дараах мэдэгдлийг гаргаж байна:

1. Нэгж эрх бүртгүүлэх ёргөдлийн маягт болон Биржийн "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ын дагуу шаардлагатай бүхий л материалыг Биржид хүргүүлсэн.
2. Бид хуульд заасан хэм хэмжээний хүрээнд өөрсдийн хүчин чадлаа дайчлан бодитой лавлагааг хийж, судалсны үр дүнд доорх зүйлсийг баталгаажуулснаа мэдэгдэж байна:
  - 2.1.1. ХОМК нь Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж, дүрэм журмын бүхий л нөхцлийг мөрдөж ажилласан ба хүргүүлсэн материал шаардлагатай мэдээлтүүдийг бүрэн агуулсан, материал орхигдуулаагүй болно.
  - 2.1.2. Нэгж эрхийн танилцуулга болон нэгж эрх бүртгүүлэх ёргөдөлтэй хамт хүргүүлж буй ХОМК-ийн дүгнэлтийг үнэн зөв, бодитой, бүрэн хийгдсэн гэж үзэж байна.
  - 2.1.3. ХОМК нь нэгж эрхээ санал болгон худалдаж буй хөрөнгө оруулалтын сан болон түүний хувь эзэмшигчидтэй холбоо хамааралгүй бөгөөд бие даасан хөндлөнгийн дүгнэлт гаргасан.
  - 2.1.4. Бид судалгаа шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, нэгж эрхийн танилцуулга бэлтгэх зэрэг ажиллагаанд шаарддагдах мэргэшсэн, туршлагатай, холбогдох саналаа илэрхийлэх хангалттай нөөц бололцоотой гэж үзэж байна.
  - 2.1.5. Сангийн удирдлагууд нь сангийн үйл ажиллагааг дангаар болон бие даан удирдах туршлага, мэдлэг, чадвартай бөгөөд нэгж эрхээ Биржид бүртгүүлснээр хүлээх үүрэг хариуцлагаа ухамсарласан. Сан нь нэгж эрхээ бүртгүүлэхээс өмнөх болон бүртгүүлсэний дараах дагаж мөрдөх дүрэм журам, удирдлагын үүрэг хариуцлагатай холбоотой дотоод дүрэм журмыг бий болгосон гэж үзэж байна.

Баталгаажуулсан:

Овог, нэр: .....

Албан тушаал: Хөрөнгө оруулалтын  
менежментийн

"....." .... К-ийн

Гарын үсэг:  
(Тамга/тэмдэг)

Баталгаажуулсан:

Овог, нэр: .....

Албан тушаал: Хөрөнгө  
оруулалтын менежментийн

"....." .... К-ийн

Гарын үсэг:  
(Тамга/тэмдэг)

### ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭ, БҮТЭЦ

A	Сангаас гарах нийт зардал /хөрөнгийн тухайн үеийн үнэ цэнээс жил бүр төлөх хувь хэмжээ/	%
1	Нийт үйлчилгээний зардлын хувь хэмжээ, жилээр	
1.1	- Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээнд	
1.2	- Хөрөнгө хадгалах үйлчилгээнд	
1.3	- Багц бүрдүүлэлтэнд /арилжааны шимтгэл, хураамж/	
1.4	- Бусад /зар сурталчилгаа, аудит гэх мэт/	
Б	Нэгж эрх эзэмшигчээс гарах зардал /хөрөнгө оруулалтын дүнгээс/	
2	Нэгж эрх худалдан авах, худалдахтай холбоотой зардал	

Батлав. МХБ ХК-ийн  
Гүйцэтгэх захирал  
.....  
/ ..... /

Батлав. " ....."  
.....-ийн .....  
.....  
/ ..... /

## ХАМТЫН ХААЛТТАЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН ГЭРЭЭ

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 37 тоот  
тогтооолоор шинэчлэн найруулсан/

.... оны .... дугаар  
сарын .....-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас "Монголын Хөрөнгийн Бирж" ХК /цаашид Бирж гэх/, түүнийг төлөөлж, ..... , негеө талаас "....." хамтын хөрөнгө оруулалтын сан /цаашид Сан гэх/-ийг төлөөлж ..... нар /хамтад нь Талууд гэх/ дараах нехцлийг харилцан тохиролцож байгуулав.

### Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээгээр Бирж нь Сан, түүний гаргасан нэгж эрхийг бүртгэх, нэгж эрхийн арилжааг зохион байгуулах ажиллагааг зохих дүрэм, журмын дагуу хийж гүйцэтгэх, Сан нь холбогдох журмын дагуу Биржид бүртгэлтэй байх хугацаанд зохих үүргийг хүлээх, үйлчилгээний төлбөр төлөхтэй холбогдон үүсэх харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлно.
- 1.2. Бирж нь Сангийн гаргасан ..... / ..... ..... / төгрөгийн нэрлэсэн үнэтэй ..... ширхэг, нийт / ..... ..... / төгрөгийн нэгж эрхийг Биржийн бүртгэлд бүртгэнэ.
- 1.3. Талуудын хооронд үүсэх энэхүү гэрээгээр зохицуулаагүй харилцааг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Санхүүгийн Зохицуулах Хороо /цаашид Хороо гэх/, Биржээс баталсан журам, заавраар зохицуулна.
- 1.4. Гэрээ нь талууд харилцан гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж, сангийн нэгж эрх нь Биржийн бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болно.
- 1.5. Энэхүү гэрээнд хэрэглэгдсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
  - 1.5.1. "Биржийн журам, заавар" гэж Биржийн үнэт цаасны бүртгэл, арилжаа, хяналт шалгалт, мэдээлэл, гишүүнчлэлийн асуудлыг зохицуулсан Биржээс гаргасан дүрэм, журам, заавар, аргачлалыг;
  - 1.5.2. "Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл" гэж өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ цацдаг радио, телевиз, Сангийн болон Биржийн цахим хуудсыг;
  - 1.5.3. "Олон нийтэд мэдээлэх" гэж холбогдох мэдээллийг Сангийн болон Биржийн цахим хуудас, бусад олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтэлснийг.

### Хоёр. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС

- 2.1. Сан нь Биржид дараах хөлсийг төлнэ. Үүнд:
  - 2.1.1. Өргөдлийг хүлээн авч хянах үйлчилгээний хөлс - 2,000,000 /хоёр сая/ төгрөг;
  - 2.1.1.1. Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс - Нийт бүртгүүлсэн үнийн дунгийн 0.25% байх ба хамгийн багадаа 25,000,000 төгрөг, хамгийн ихдээ 100,000,000 төгрөг;

- 2.1.2. Жилийн үйлчилгээний хэлс - Сангийн цэвэр хөрөнгийн дүнгийн 0.025%, хамгийн багадаа 2,500,000 төгрөг, хамгийн ихдээ 50,000,000 төгрөг.
- 2.2. Гэрээний 2.1.1-т заасан төлбөрийг Биржид хүсэлт гаргахаас өмнө төлсөн байх бөгөөд буцаан олгогдохгүй.
- 2.3. Гэрээний 2.1.2-т заасан төлбөрийг анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдсан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор Биржийн дансанд шилжүүлнэ.
- 2.4. Гэрээний 2.1.3-т заасан төлбөрийг тухайн оны нэгдүгээр улиралд багтаан Биржийн дансанд шилжүүлнэ.
- 2.5. Гэрээний 2.1.3-т заасан сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээг тухайн сангийн өнгөрсөн оны сүүлийн сарын цэвэр хөрөнгийн дундаж үнэ цэнээр тооцно.
- 2.6. Сан нь анх удаа нэгж эрхээ Биржид бүртгүүлэх тохиолдолд тухайн оны жилийн үйлчилгээний хэлс төлөхөөс чөлөөлгднө.
- 2.7. Сан нь бүртгэлээс хасагдах тохиолдолд тухайн жилийн бүртгэлтэй байх хоногт хувь тэнцүүлэн жилийн үйлчилгээний хэлсийг төлж болно.
- 2.8. Үнэт цаасны арилжааг зогсоосон нь жилийн үйлчилгээний хэлс төлөхгүй байх үндэслэл болохгүй.

**Гурав. БИРЖИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

**3.1. Бирж нь дараах эрх эдэлнэ. Үүнд:**

- 3.1.1. Нэгж эрхийн арилжаанд хяналт тавих, тодорхой чиглэл удирдамжийн дагуу шалгалт хийх;
- 3.1.2. Нэгж эрх эзэмшигчдийн эрх ашгийг хөндсөн асуудлаар сангаас гаргасан аливаа шийдвэр нь хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд хяналт тавих;
- 3.1.3. Шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг сангаас гаргуулан авах;
- 3.1.4. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хөндсөн аливаа асуудлаар сангаас тайлбар, тодруулга шаардан авах;
- 3.1.5. Сангаас ирүүлсэн мэдээ, мэдээллийг олон нийтэд мэдээлэх, мэдээллийг олон нийтэд хүргэх талаар санд шаардлага тавих;
- 3.1.6. Сан нь холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн, Биржээс тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд олон нийтэд мэдээлэх;
- 3.1.7. Санд үзүүлсэн үйлчилгээний хэлсийг гэрээний 2 дугаар зүйлд заасны дагуу шаардах;
- 3.1.8. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан нийтлэг үүргээ биелүүлэн ажиллах талаар санд шаардлага тавих;
- 3.1.9. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Сангийн бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагаанд холбогдох журам, удирдамжийн дагуу тусгай шалгалтыг хийх;
- 3.1.10. Сан нь холбогдох хууль, дүрэм, журам зөрчсөн тохиолдолд эрх хэмжээнийхээ хүрээнд Биржийн "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам", "Хяналт шалгалтын журам", энэ гэрээний дагуу хариуцлага тооцох;
- 3.1.11. Хууль, журамд заасан бусад эрх.

**3.2. Бирж нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:**

- 3.2.1. Сангийн гаргасан нэгж эрхийг Биржийн бүртгэлд бүртгэж, нэгж эрхийн арилжааг зохион байгуулах ажиллагааг зохих дүрэм, журмын дагуу хийж гүйцэтгэх;
- 3.2.2. Сангийн хүсэлтээр хөрөнгийн зах зээлтэй холбоотой асуудлаар зохих журам, шийдвэрийн хүрээнд зөвлөгөө, зааварчилгаа өгөх, сургалт, семинар зохион байгуулах;

- 3.2.3. Сантай холбоотой Биржийн журам, зааварт өөрчлөлт орсон нөхцөлд энэ талаар болон шаардлагатай мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан Санд мэдэгдэх;
- 3.2.4. Сангийн нэгж эрхийн бүртгэл, арилжаатай холбоотой мэдээ, судалгааг зохих журмын дагуу Сангийн хүсэлтээр гаргаж өгөх;
- 3.2.5. Сангаас олон нийтэд мэдээлэхээр ирүүлсэн мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан мэдээлэх.

**Дөрөв. САНГИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

**4.1. Сан нь дараах эрх эдэлнэ. Үүнд:**

- 4.1.1. Нэгж эрх бүртгүүлэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасуулах тухай өргөдөл гаргах;
- 4.1.2. Бүртгэгдсэн нэгж эрхийг Хорооны зөвшөөрлийн дагуу анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаанд оруулах хүсэлт гаргах;
- 4.1.3. Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурал хуралдуулах, үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулахтай холбоотой асуудлаар Биржээс заавар, зөвлөмж авах;
- 4.1.4. Нэгж эрхийн бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Биржид санал хүсэлт гаргах, журамд заасан хугацаанд үндэслэл бүхий хариу авах, шийдвэрлэх асуудлаар харилцан зөвшилцэх;
- 4.1.5. Холбогдох дүрэм, журамд заасан нөхцлийг хангасан тохиолдолд нэгж эрхийн бүртгэл, арилжаатай холбогдох мэдээлэл, судалгааг авах;
- 4.1.6. Сантай холбоотой Биржээс гаргасан шийдвэрийн талаар аливаа гомдолоо Хороонд гаргах.

**4.2. Сан нь дараах үүрэгтэй. Үүнд:**

- 4.2.1. Сан нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасан хөрөнгө оруулагчдын болон эрх бүхий байгууллагын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж ажиллах, хууль тогтоомжийн хүрээнд Хороо, Биржээс баталсан журам, зааврыг дагаж мөрдөх;
- 4.2.2. Өөрийн нэгж эрхийг эзэмшигч, хөрөнгө оруулагчдад шударга, тэгш хандах;
- 4.2.3. Батлагдсан хөрөнгө оруулалтын бодлогыг чанд мөрдөж, Биржийн нэгж эрхийн бүртгэлийн журмын 3 ба 4 дүгээр зүйлд заасан шалгуур шаардлага, үүргийг бүртгэлтэй байх хугацаандаа бурэн биелүүлж ажиллах, тус журмын 4.2.1-д заасан сангийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, сангийн активын бүрэлдэхүүн, хөрвөх чадварын шалгуур үзүүлэлтийг байнга хангаж ажиллах;
- 4.2.4. Нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагаанд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 6 дугаар бүлэг, Хорооны холбогдох журам, зааврыг мөрдөх;
- 4.2.5. Хууль, журамд заасан зар сурталчилгаа, маркетингийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, хязгаарлалтыг баримтлах;
- 4.2.6. Сан нь хөрөнгө оруулагчдад болон Биржид мэдээлэл хүргэх талаар дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
  - 4.2.6.1. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Бирж болон Хорооны холбогдох журмуудад заасан хөрөнгө оруулагчдад хүргэхээр заасан мэдээллийг тогтоосон хугацаанд гаргаж, олон нийтэд мэдээлэх ба Биржид мэдэгдэх, цахим болон хэвлэмэл байдлаар ирүүлэх;
  - 4.2.6.2. Биржид мэдээ мэдээлэл ирүүлэх, Биржтэй харилцах этгээдийг томилж, түүний нэр, албан тушаал, холбоо барих утас, цахим шуудангийн хаягийг ирүүлэх, өөрчлөлт орсон тухай бүр мэдэгдэх;

- 4.2.6.3. Сангийн цэвэр хөрөнгийн үнэ цэнийг өөрийн цахим хуудас болон Биржийн цахим хуудсаар дамжуулан өдөр бүр биржийн арилжаа явагдаж дууссанаас хойш 21 цагийн дотор буюу дараагийн өдрийн арилжаа эхлэхээс өмнө нийтэд мэдээлэх;
  - 4.2.6.4. Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Биржийн нэгж эрхийн бүртгэлийн журмын 4.2.7-д заасны дагуу гаргаж, заасан хугацаанд ирүүлэх;
  - 4.2.6.5. Холбоотой этгээдтэй хийсэн хэлцэл гүйлгээ, сангийн активын бүтэц бүрэлдэхүүн, хөрвөх чадварын талаарх мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд заавал тусгах;
  - 4.2.6.6. Сангийн жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг гарсан даруйд ирүүлэх, нийтэд мэдээлэх;
  - 4.2.6.7. Нэгж эрх эзэмшигчдийн хурлын зар мэдэгдэл, нэгж эрх эзэмшигчдийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр, Биржийн нэгж эрхийн бүртгэлийн журмын 4.2-т заасан мэдээллийг ажлын 2 хоногийн дотор ирүүлэх;
  - 4.2.6.8. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн тавдугаар бүлэгт туссан анхдагч болон хоёрдогч зах зээлийн мэдээллийг бичгээр болон цахим хэлбэрээр ирүүлэх, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэх;
  - 4.2.6.9. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу нэгж эрхийн үнэ ханшид нөлөөлж болох, үнэт цаасны арилжаанд оролцоход давуу тал опгох нийтэд тараагдаагүй мэдээллийг хөрөнгө оруулагч бусад этгээдэд нэгэн зэрэг, тэгш хүргэх, уг мэдээллийг дараа өдрийн арилжаанаас өмнө Биржид мэдэгдэх;
  - 4.2.6.10. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 26.5, 34.1, 36.1-д заасан нөхцөл байдал үүссэн, үүсэх нь тодорхой болсон даруйд Биржид мэдэгдэх;
  - 4.2.6.11. Хууль тогтоомжид заасан болон нэгж эрх эзэмшигчдийн эрх ашиг, хөрөнгө оруулагчдын шийдвэрт нөлөөлөх, зах зээлийг урвуулан ашиглах, дотоод мэдээлэлд хамаарах бусад мэдээллийг тухай бүр ирүүлэх, нийтэд мэдээлэх.
- 
- 4.2.7. Гэрээний 2 дугаар зүйлд заасан хөлсийг тогтоосон хугацаанд төлөх;
  - 4.2.8. Гэрээний 4.2.6.3-т заасан сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээг тооцохдоо Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 39.4-т заасныг баримтлах. Хэрэв энэхүү тооцооплыг хэд хэдэн этгээд давхар гүйцэтгэж байгаа бол түүнийг мөн Биржид тогтмол ирүүлэх, тэдгээр тооцооплын хооронд зөрүү үүсвэл тайлбарыг хавсаргах;
  - 4.2.9. Сан нь хууль, журмын хүрээнд Биржээс тавьсан шаардлагыг биелүүлж ажиллах, шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодруулгыг гаргаж өгөх, нэгж эрх худалдах замаар хуримтлуулсан хөрөнгийн зарцуулалт, мэдээллийн ил тод байдалтай холбоотой асуудлын хүрээнд шалгуулах;
  - 4.2.10. Сан нь үнэт цаасны зах зээл дээр мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, гэрээний үүргийн биелэлттэй холбогдуулан Биржээс тавьсан шаардлагыг биелүүлж, хариу мэдэгдэх;
  - 4.2.11. Биржээс тавьсан хууль ёсны шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд энэ тухай шалтгаан бүхий тайлбарыг Биржид ажлын 3 хоногийн дотор бичгээр хүргүүлэх;
  - 4.2.12. Гэрээний 4.2.11-д заасны дагуу тайлбар ирүүлээгүй нөхцөлд шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

Тав. ХАРИУЦЛАГА

- 5.1. Сан нь гэрээний 4.2-т заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд Биржийн зүгээс хууль тогтоомж, дүрэм, журмаар олгогдсон эрх хэмжээний хүрээнд Нэгж эрхийн бүртгэлийн журмын 5 болон 7 дугаар зүйлд заасан арга хэмжээг авч, хариуцлага хүлээлгэнэ.
- 5.2. Мэдээллийн үнэн зөвийг мэдээлэл гаргагч талууд хариуцна.
- 5.3. Үнэт цаас гаргагч нь гэрээний 4.2.6-д заасан үүргээ зөрчсөн тохиолдолд Иргэний хуулийн 232.5-д заасны дагуу мэдээний төрөл бүрт 100 000 төгрөгийн анзыг Биржид төлнө.
- 5.4. Энэхүү гэрээний 2 дугаар зүйлд заасан үйлчилгээний хөлсийг заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд Биржийн нэгж эрхийн бүртгэлийн журмын 7.2-т заасны дагуу алданги тооцно.
- 5.5. Сангийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан нэгж эрхийн арилжааг зогсоох болон бусад арга хэмжээтэй холбогдон нэгж эрх эзэмшигч, бусад этгээдэд учирсан хохирлыг Бирж хариуцахгүй.
- 5.6. Нэгж эрхийн танилцуулга, холбогдох бусад баримт бичигт худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, зөрүүтэй, алдаатай мэдээлэл тусгасны улмаас бусдад хохирол учруулсан бол уг хохирлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Сан, уг шийдвэрийг гаргасан эрх бүхий албан тушаалтан хамтран хариуцна.

#### Зургаа. БУСАД

- 6.1. Гэрээ гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
- 6.2. Талуудын хүсэлтээр харилцан тохиролцож гэрээнд өөрчлөлт оруулж болно.
- 6.3. Энэхүү гэрээний зарим заалт нь хуулиар хүчин төгөлдөр бусд тооцогдох бол уг заалтыг оролцуулахгүйгээр гэрээг хүчин төгөлдөр хэвээр үргэлжлүүлэхийг талууд хүлээн зөвшөөрсэн болно.
- 6.4. Талуудын хооронд гарсан маргаантай асуудлыг харилцан зөвшилцэж шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд зөвшилцэлд хүрч чадахгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Биржийг төлөөлж:

.....

.....

/...../

Үнэт цаас гаргагчийг төлөөлж:

“.....”-ИЙН

.....

/...../

Маягт 5

Лөлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 37 тоот тогтоолоор  
нэмсэн/

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАГЦЫН УЛИРЛЫН МЭДЭЭЛЭЛ**  
**/ХОМК-д зориулсан маягт/**

Нэг	Ерөнхий мэдээлэл	Тайлбар
1.1	ХОМК-ийн нэр	
1.2	Тусгай зөвшөөрлийн дугаар	
1.3	ХОМК-ийн регистрийн дугаар	
1.4	Хаяг, утасны дугаар	
1.5	Удирдаж буй сангийн нэр	
1.6	Сангийн нэгж эрхийн нэр /хэрэв байгаа бол/, үсгэн код	
1.7	Сангийн регистрийн дугаар	
1.8	Тайлангийн огноо	
<b>Хоёр</b>	<b>Сангийн мэдээлэл</b>	
2.1	Сангийн хөрөнгө, өр төлбөрийн дүн /төгрөгөөр/	
2.1.1	Нийт хөрөнгө	
2.1.2	Нийт өр төлбөр	
2.1.3	Цэвэр хөрөнгө	
2.2	Бусад хөрөнгө, өр төлбөрийн дэлгэрэнгүй мэдээлэл:  Хөрөнгө оруулалтын багц /портфолио/-д оруулсан хөрөнгө оруулалтын дүнгээс бусад хөрөнгө ба өр төлбөрийн дүн /төгрөгөөр/	Маягтын 3, 4-т тусаагүй хөрөнгө ба өр төлбөрийг зүйл тус бүрээр тусгана. Тухайлбал, мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, менежментийн өр төлбөр г.м.)
2.3	<b>Сангийн өгөөжийн мэдээлэл</b>	
2.3.1	Өмнөх улирлын болон тухайн улирлын сангийн хөрөнгө оруулалтын Нийт өгөөж	Өгөөж тооцох аргачлалыг “Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг үнэлэх олон улсын стандарт” /GIPS/-аас үзнэ үү.
2.3.2	Өмнөх улирлын болон тухайн улирлын хэрэгжсэн цэвэр олз /гарз/, хэрэгжээгүй үнийн дүнгийн өсөлт /бууралт/-ын цэвэр өөрчлөлт	Гарз болон бууралтын дүнг сөрөг тэмдгээр илэрхийлэх
2.4	<b>Сангийн хөрөнгө оруулалтын бодлого</b>	
2.4.1	Хөрөнгө оруулалтын бодлогод тусгасан зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтын хэрэгсэл, тэдгээрийн хязгаарлалт /үнэт цаасны төрөл, гадаад, дотоод зах зээл тус бүрээр/	Жишээлбэл, хувьцаа 80% /үүнээс дотоодын зах зээл дэхь хувьцаанд 70%, гадаадын зах зээлд 10%/ г.м.
2.4.2	Хөрөнгө оруулалтын бодлогод туссан мөнгөн хөрөнгөнд байршуулж болох хөрөнгийн дээд хязгаар	
2.4.3	Тайлангийн хугацаанд сангийн хөрөнгө оруулалтын хэмжээ дээрх хязгааруудаас хэтрээгүй/хэтэрсэн эсэх, хэтэрсэн бол түүний шалтгаан	
<b>Гурав</b>	<b>Хөрөнгө оруулалтын багцын мэдээлэл</b> Хөрөнгө оруулалтын багц дахь зах зээлийн үнийн дүн нь сангийн нийт хөрөнгийн 5 ба түүнээс дээш хувийг бүрдүүлж буй үнэт цаасны мэдээллийг үнэт цаас тус бүрээр тусгана.	Зах зээлийн үнийн дүн нь сангийн нийт хөрөнгийн 5 хувиас бага хөрөнгө оруулалтыг энэхүү маягтын 4-т заасан “Бусад үнэт цаас” гэж тайлагнана.
3.1	Хөрөнгө оруулсан үнэт цаас гаргагчийн нэр /хэрэв байгаа бол/	
3.2	Үнэт цаасны нэр	
3.3	Үнэт цаасны төрөл	
3.4	Үнэт цаасны тикер /үсгэн код/	
3.5	Үнэт цаасны тоо ширхэг	

3.6	Үнэт цаасны нэрлэсэн үнэ, нийт үнийн дүн /төгрөг, гадаад валют/	ХО-т хийсэн валютаар илэрхийлэх
3.7	Хөрөнгө оруулалт /ХО-т/-ын зах зээлийн үнэ санхүүгийн хэрэгсэл тус бүрээр /төгрөгөөр илэрхийлэх/ Хэрэв ХО-тыг гадаад валютаар хийсэн бол тооцоололд ашигласан гадаад валютын ханшийн мэдээлэл	ХО-тын ЗЗҮ-ийг тайлангийн хугацааны эцсийн өдрийн хаалтын ханшаар тооцно.
3.8	Хөрөнгө оруулалтын зах зээлийн үнэ ба сангийн цэвэр хөрөнгийн харьцаа /%-иар илэрхийлэх/	ХО-тын ЗЗҮ цэнийг Сангийн цэвэр хөрөнгөнд харьцуулсан хувь хэмжээ
3.9	Хөрөнгө оруулалт хийсэн санхүүгийн хэрэгслийн төрөл /хувьцаа, өрийн хэрэгсэл, ХБҮЦ г.м/	
3.10	Үнэт цаас гаргагчийн хэлбэр /нээлттэй, хаалттай компани, засгийн газар г.м/	
3.11	Хөрөнгө оруулалт хийсэн улс, эсхүл ҮЦГ-ийн мэдээлэл	Хэрэв ҮЦГ-ийн үүсгэн байгуулагдсан/үйл ажиллагаа явуулж буй улс нь ХО-т хийсэн/ҮЦ худалдан авсан улсаас өөр бол уг мэдээллийг нэмж тусгах
3.12	ХО-тын багцын хөрвөх чадвартай холбоотой мэдээлэл:  Хөрвөх чадвар муутай хэрэгсэлд оруулсан хөрөнгө оруулалтын ЗЗҮ ба Сангийн цэвэр хөрөнгийн харьцаа /%-иар илэрхийлэх/	ХО-тын багц дахь хөрвөх чадвар муутай үнэт цаас тус бүрийн мэдээллийг тусгах ба хөрвөх чадвар муутай хэрэгсэл гэдгийг Хорооны холбогдох журамд зааснаар ойлгоно.
3.13	Өрийн хэрэгсэлд оруулсан хөрөнгө оруулалтын дэлгэрэнгүй мэдээлэл	
3.13.1	Өрийн хэрэгслийн хугацаа, хүүгийн хувь хэмжээ, хүүгийн төрөл /тогтмол, хөвөгч, хувьсах г.м/	
3.13.2	Өрийн хэрэгсэл гаргагч төлбөрийн чадваргүй болох нөхцөл байдал үүссэн эсэх, дефолтын нөхцөл байдал үүссэн эсэх	Тийм/Үгүй гэж хариулна, хэрэв “Тийм” бол нэмэлт тайлбар мэдээлэл оруулна.
3.13.3	Хүүгийн болон үндсэн төлбөр хойшлогдсон, хугацаандаа төлгөөгүй тохиолдол гарсан эсэх	
Дөрөв	Бусад үнэт цаас  Хөрөнгө оруулалтын багцад орсон зах зээлийн үнийн дүн нь сангийн нийт хөрөнгийн 5 хувиас бага үнэт цаасны мэдээлэл	Маягтын 3 дугаар зүйлд заасантай адил агуулгаар мэдээллийг тусгах ба энэхүү мэдээлэл нь олон нийтэд мэдээлэгдэхгүй болно.
Тав	Нэмэлт тайлбар, тодруулга	Шаардлагатай бол нэмэлт тайлбар тодруулга оруулна.
Зургаа	Ил тод болгох: Энэхүү маягтын дагуу гаргасан 2 дугаар улирлын тайланг хүснэгт хэлбэрт оруулж, сангийн үйл ажиллагааны хагас жилийн тайланд хавсарган, олон нийтэд мэдээлнэ.	

### ГАРЫН ҮСЭГ

/ХОМК-ийн нэр, гарын үсэг зурах эрх бүхий этгээдийн овог нэр, гарын үсэг, албан тушаал, огноо/